

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРОО

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 6
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	7 – 64

1.	<i>“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	8 – 49
2.	<i>Хууль, тогтоолын үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан</i>	49 – 64

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 11 дүгээр сарын 11-ний өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 30 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

*Томилолттой: А.Ундраа, С.Цэнгүүн;
Чөлөөтэй: Ч.Анар, Ц.Баатархүү, Х.Булгантуяа, Р.Сэддорж;
Тасалсан: Ж.Бат-Эрдэнэ, О.Цогтгэрэл.*

Нэг. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд Д.Батлут, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундром, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

Б.Насантогтох, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Даваацэрэн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Золбаяр, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Батцэцэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, Нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогч Т.Даваадалай, Нийслэлийн Засаг даргын хоёрдугаар орлогч А.Амартүвшин, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Амгалан, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Хадбаатар, Гадаад харилцааны яамны Бодлогын газрын захирал Г.Бямбасүрэн, мөн яамны Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ч.Гандирваа, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Оюунгэрэл, Боловсролын яамны Боловсролын судалгааны Үндэсний хүрээлэнгийн захирал П.Оюунаа, Боловсролын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Бадамжав, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн газрын дарга Б.Алимаа, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Ю.Отгонбилэг, Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын зөвлөх Ж.Эрхэмтөгс, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга Ц.Борхүү, “Эрдэнэс Монгол” компанийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай, Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын зөвлөх Б.Ганбат, Шинжлэх ухааны академийн академич А.Бакей, Шинжлэх ухааны академийн академич С.Нямзагд, Шинжлэх ухааны академийн академич Д.Дагвадорж, Шинжлэх ухааны академийн академич Т.Дорж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр төслийн Үр дүнд суурилсан төлөвлөлтийн зөвлөх Г.Цэрэнжаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнхтөр, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан, Бизнесийн орчны бодлогын газрын дарга Л.Балчинлуvsан, Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэтуяа, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал,

Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, мөн газрын Тогтвортой хөгжлийн нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Чандмань, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Төгөлдөр, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын ахлах шинжээч Д.Сугар, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн З.Райымбек, Г.Отгонцэцэг, Зам, тээврийн яамны Авто замын бодлого зохицуулалтын газрын дарга Ч.Сугармаа, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Г.Батбаяр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Энх-Эрдэнэ, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Г.Эрдэнэбулган, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Энхтүвшин, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Пунцагбалжир, Хилийн боомтын захиргааны дарга Б.Батхишиг, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газрын дарга Д.Энхбаатар, мөн яамны Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газрын дарга М.Ням-Очир, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Уянга, Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газрын дарга О.Одбаяр, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Туяа, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Э.Оюунсүрэн, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Их өгөгдөл, судалгааны албаны дарга Г.Дамба, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Д.Булгантамир, мөн яамны Эм, эмнэлгийн хэрэгслийн газрын дарга Н.Эрдэнэбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч Д.Баярсайхан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Т.Золбаяр, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Ойн газрын дарга Б.Оюунсанаа, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч С.Эрдэнэцэцэг, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Д.Дэчин, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Аж үйлдвэрийн бодлогын газрын дарга М.Мэндбаяр, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга Б.Нандинболор, Хил хамгаалах ерөнхий газрын дарга Ж.Бямбасүрэн, мөн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ц.Чойжилсүрэн, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Давааням, Шүүх шинжилгээний ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга Б.Амар, Цагдаагийн Ерөнхий газрын Тэргүүн дэд дарга Б.Ганчулуун, Цагдаагийн Ерөнхий газрын Дэд дарга О.Ганбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх

Б.Нандингэрэл, референт Б.Ууганцэцэг, Т.Билэг-Өрнөх, Х.Шижирмөнх, М.Мандхай нар байлцав.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Л.Соронзонболд, М.Энхцэцэг, П.Батчимэг, Г.Очирбат, Ж.Золжаргал, М.Мандхай нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, “Эрдэнэс Монгол” компанийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, Шинжлэх ухааны академийн академич А.Бакей нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай, М.Энхцэцэг, Г.Очирбат, Ж.Энхбаяр нар үг хэлэв.

Ч.Лодойсамбуу: “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	12
Бүгд:	24

50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хууль, тогтоолын үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Батцэцэг, мөн газрын Үнэлгээ, мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Золбоо, Үнэлгээ, мониторингийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Баярсүх, Үнэлгээ мониторингийн хэлтсийн референт Д.Даваасамбуу нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нандингэрэл, референт Б.Ууганцэцэг, Т.Билэг-Өрнөх, Х.Шижирмөнх, М.Мандхай нар байлцав.

Хууль, тогтоолын үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг Сангийн сайд Б.Жавхлан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай, Д.Үүрийнтуяа, Г.Очирбат нарын тавьсан асуултад Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Батцэцэг хариулж, тайлбар хийв.

Уг асуудлыг 15 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 26 минут үргэлжилж, 32 гишүүнээс 24 гишүүн хүрэлцэн ирж, 75.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 56 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, Мягмар гараг
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхим
12 цаг 30 минут

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ч.Лодойсамбуу: Байнгын хорооны эрхэм гишүүд, ажлын хэсгийнхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Жуковын Алдаржавхлан гишүүн ирсэн байна, Пүрэвийн Батчимэг гишүүн ирсэн байна, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн ирсэн байна, Ренчиндоржийн Батболд гишүүн ирсэн байна, Шинэбаярын Бямбасүрэн гишүүн ирсэн байна, Пүрэвжавын Ганзориг гишүүн ирсэн байна, Батжаргалын Заяабал гишүүн ирсэн байна, Мэндбаярын Мандхай гишүүн ирсэн байна, Бадрахын Найдалаа гишүүн ирсэн байна, Эрдэнэбилэгийн Одбаяр гишүүн ирсэн, Ганбатын Очирбат гишүүн ирсэн, Бадамдоржийн Пунсалмаа гишүүн ирсэн, Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн ирсэн, Болдын Уянга гишүүн ирсэн, Мөнхчулууны Энхцэцэг гишүүн ирсэн, Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн ирсэн байна.

Байнгын хорооны дарга өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаан Байнгын хорооноос чөлөө авсан байгаа.

Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 53.1 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт, “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Засгийн газар 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэхийг хэлэлцэнэ.

Хоёрдугаарт, Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэг. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх
таван жилийн үндсэн чиглэл батлах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл
/Засгийн газар 2025.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэх асуудал. Нэг. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Тогтоолын төслийн талаарх хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ням-Осорын Учрал танилцуулна.

Н.Учрал сайдын микрофоныг өгье.

Н.Учрал: Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна гэж, хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт Засгийн газар Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төслийг өмнөх үндсэн чиглэлийн баримт бичиг дуусгавар болохоос хоёр сарын өмнө Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гэж заасны дагуу “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх эсэхийг шийдвэрлүүлэхээр хэлэлцүүлж байна.

Уг төлөвлөлтийн баримт бичгийг урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан судалгаа, шинжилгээнд тулгуурлаж, зорилго зорилт нь хэмжигдэхүйц, шалгуур үзүүлэлт нь зорилгодоо нийцсэн төлөвлөлт нь үр дүнд чиглэсэн байдлаар бүх талын оролцоог хангаж, нийт 40 төсвийн ерөнхийлөн захирагчтай хамтран боловсрууллаа.

Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төсөл нь шинэ итгэл, эрс шинэтгэлд зорин хүний хөгжил, нийгмийн хөгжил ба үндэсний нэгдмэл үнэт зүйл, эдийн засаг ба дэд бүтцийн хөгжил, байгаль орчин, ногоон эдийн засаг, засаглал, дижитал шилжилт, бүсийн хөгжил, үндэсний өрсөлдөх чадвар, шинжлэх ухаан, технологи, хиймэл оюун гэсэн бодлогын 8 чиглэлээс бүрдэх бөгөөд энэ хүрээнд –

- үндэсний 10,
- салбарын 35,
- төсвийн ерөнхийлөн захирагчийн 85,
- хөтөлбөрийн 200 үр дүн,
- нийт 330 үр дүнг тодорхойллоо.

Бид эдгээр үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжлийн зорилгын шалгуур үзүүлэлтүүдтэй уялдуулж тодорхойлсон нь олон улсад хүлээсэн манай улсын үүрэг амлалтыг биелүүлэх, нөгөө талаас уг баримт бичгийн боловсруулалтын чанарыг сайжруулахад чухал алхам боллоо гэж үзэж байна.

Дээрх бодлогын 8 чиглэлийн хүрээнд үндэсний 10 үр дүнг дараах байдлаар тодорхойлж тусгалаа. Үүнд:

1. Чанартай, хүртээмжтэй боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг иргэн бүрд тэгш хүргэж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн хүний нөөцийг бэлтгэн хүний хөгжлийн үзүүлэлт 0.756 байгааг 0.813 оноонд хүргэх.
2. Хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлж, цалин хөлс, нийгмийн даатгалын уялдаа холбоог сайжруулах замаар зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, дундаж давхаргын эзлэх хувь тооцохгүй байгааг тооцож 2030 онд 20 хувиар нэмэгдүүлэх.
3. Эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн үндэсний соёлын дархлааг бэхжүүлж, эв нэгдлийг бататган үндэсний нэгдмэл үнэт зүйлсийн үзүүлэлт 2021 онд 49 хувь байгааг 55 хувьд хүргэх.
4. Эрүүл, аюулгүй амьдрах орчин, хүртээмжтэй орон сууц, чанартай нийгмийн хамгааллын үйлчилгээгээр амьдралын чанарыг дээшлүүлж, гэр бүлийн эрүүл, тогтвортой байдлыг бэхжүүлж, хүүхдийн хөгжил, хамгааллыг шинэ шатанд гаргаж, нийгмийн сайн сайхан байдлын үзүүлэлтийг тооцохгүй байгааг тооцож 20 хувиар өсгөх.
5. Боловсруулах салбарын боловсруулалтын түвшнийг дээшлүүлж, бүтээмж, төрөлжилтийг нэмэгдүүлснээр эдийн засгийн тогтвортой өсөлт 5.1 хувьтай байгааг 6 хувиас дээш түвшинд тогтвортой хадгалах.
6. Анхдагч эко системийн тэнцвэрийг хангаж, уур амьсгалын өөрчлөлтийг сайжруулж, байгалийн нөөц баялгийн нөхөн сэргээлт, зохистой ашиглалтыг дэмжиж, байгаль орчинд ээлтэй технологийг нэвтрүүлж, байгаль орчны гүйцэтгэлийн үзүүлэлт 37.2 байгааг 59 оноонд хүргэх.
7. Авлигыг бууруулж, шударга ёсны тогтолцоог бэхжүүлж, ил тод байдал,

хариуцлагыг нэмэгдүүлж, цахим засаглалыг дэмжиж, иргэн төвтэй үйлчилгээг бүрдүүлж, зөв засаглалын үзүүлэлтээр 114 дүгээр байрт байгааг 90 дүгээр байранд хүргэх.

8. Бүс, орон нутгийн хөгжлийн ялгааг багасгаж, эдийн засгийн хувьд төрөлжүүлж, хүн амын шилжилт хөдөлгөөнийг тэнцвэржүүлэх замаар орон нутгийн хөгжлийн үзүүлэлт 0.506 байгааг 0.604 болгож нэмэгдүүлэх.
9. Бизнес эрхлэх орчныг сайжруулж, зах зээл дэх төрийн оролцоог багасгах, шударга өрсөлдөөнийг дэмжих, бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, татварын болон гаалийн шинэчлэлийг гүнзгийрүүлж, Монгол Улсын өрсөлдөх чадварын үзүүлэлтээр 61 дүгээр байрт байгааг 50 дугаар байрт хүргэх.
10. Монгол Улсын хөгжилд оруулах шинжлэх ухаан, технологи, хиймэл оюун, инновацын хувь нэмрийг дээшлүүлж, төр, хувийн хэвшил, судалгааны байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлж 40 хүн оноонд хүргэнэ.

Түүнчлэн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төслийг боловсруулж, түүнд хөгжлийн төслүүдийг эрэмбэлж, 30 тэрбум төгрөгөөс дээш өртөгтэй техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл хийгдсэн хөгжлийн урт болон дунд хугацааны бодлоготой нийцсэн төсөл, арга хэмжээнүүдийг тусгалаа.

Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төсөлд санхүүжилтийн эх үүсвэр нь шийдвэрлэгдсэн 66.6 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 87 төслийг тусгасан ба нийт 55.2 их наяд төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төлөвлөлөө. Үүнээс:

- | | |
|------------|---|
| ➤ 2026 онд | 10.3 их наяд төгрөгийг; |
| ➤ 2027 онд | 14.4 их наяд төгрөгийг; |
| ➤ 2028 онд | 14.9 их наяд төгрөгийг; |
| ➤ 2029 онд | 9.1 их наяд төгрөгийг; |
| ➤ 2030 онд | 6.4 их наяд төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөлөө. |

■ Тус төслүүдийн –

- 44.8 хувь буюу 30 төслийг улс орон нутгийн төсвөөр,
- 28.7 хувь буюу 25 төслийг гадаадын зээл тусламжаар,
- 16.1 хувь буюу 14 төслийг шууд хөрөнгө оруулалтаар,
- 3.4 хувь буюу 3 төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр,
- 2.3 хувь буюу 2 төслийг Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаасаар,
- 3.4 хувь буюу 3 төслийг холимог эх үүсвэрээр,

- 1.1 хувь буюу нэг төслийг бусад эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөлөө.

Түүнчлэн Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төслийг боловсруулахдаа нийт 14 удаагийн олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, Шинжлэх ухааны академийн Бага чуулганы болон Их чуулганаараар хэлэлцүүлсэн нь шинжлэх ухаанд суурилсан бодлого боловсруулахад онцгой ач холбогдолтой боллоо гэж үзэж байна.

Олон нийтийн хэлэлцүүлэгт шүүх засаглалын байгууллага, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог байгууллага, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын албан хаагчид, иргэний нийгэм, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөлөл оролцож, нийт 644 санал гаргаснаас хууль тогтоомжид үндсэн чиглэлийн төсөлд тусгасан болно.

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсыг 2026-аас 2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье. Баярлалаа.

Ч.Лодойсамбуу: Н.Учрал сайдад баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя.

Гомбожавын Занданшатар Монгол Улсын Ерөнхий сайд. Одоо яг энэ танхимд Засгийн газрын 2 сайд байна.

Засгийн газар таван жилийнхээ үйл ажиллагааны үндсэн чиглэлийг одоо батлуулах гэж байгаа. Батлуулахаасаа өмнө амралтын өдөр хэвлэлийн хурал хийгээд сэтгүүлчдэд танилцуулсан. Хэвлэлийн хурал дээр танхим бүтнээрээ байсан. Их Хурал дээр танилцуулахаар Н.Учрал сайд байна, Чойжилсүрэн сайд байна.

Ажлын хэсэг танилцуул гээд ажлын хэсгийн нэрс байна. Бүх сайд нар байна.

Тэгэхээр Засгийн газрын тэргүүн өөрөө орж ирэх шаардлагатай. Засгийн газрын тэргүүнийг орж ирэхээр үргэлжлүүлж ажлын хэсгийг танилцуулаад асуудлаа хэлэлцье. Ерөнхий сайдаас асуулт байна.

Монгол Улсын Ерөнхий сайд хуралд орж ирлээ. Ажлын хэсгийг танилцуулъя.

Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ням-Осорын Учрал, Монгол Улсын Шадар сайд Тогмидын Доржханд орж ирээрэй. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Сандагийн Бямбацогт орж ирсэн.

Гадаад харилцааны сайд Батмөнхийн Батцэцэг, Сангийн сайд Болдын Жавхлан орж ирээрэй. Хууль зүй, дотоод хэргийн сайд Баттөмөрийн Энхбаяр орж ирээрэй. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Гонгорын Дамдинням орж ирээгүй байна. Батлан хамгаалахын сайд Дамбын Батлут, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Батын Батбаатар орж ирээгүй байна. Боловсролын сайд Пүрэвсүрэнгийн Наранбаяр, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Тилеуханы Аубакир, Зам, тээврийн сайд Борхүүгийн Дэлгэрсайхан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Чинбатын Ундрэм, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Энхтайваны Бат-Амгалан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Жадамбын Энхбаяр, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Энхбаярын Батшугар, Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн орж ирсэн байгаа. Эрүүл мэндийн сайд Жигжидсүрэнгийн Чинбүрэн орж ирээрэй.

Нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогч Түмэндалайн Даваадалай, Нийслэлийн Засаг даргын хоёрдугаар орлогч Амгаланбаярын Амартүвшин, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга Дугаржавын Амгалан, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Пагмадуламын Хадбаатар, Гадаад харилцааны яамны Бодлогын газрын захирал Гүндэвсүрэнгийн Бямбасүрэн, Гадаад харилцааны яамны Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Болдын Отгонцэцэг, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жигжидийн Ганбат, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Нэргүйн Мягмар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Нармандахын Жамъянхүү, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Буриадын Дашпүрэв, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, хошууч генерал Дагвадоржийн Ганхуяг, Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, бригадын генерал Чулуунборын Гандирваа, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, хурандаа Бадраагийн Оюунгэрэл, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ширэнчулууны Батбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ханджавын Батжаргал, Боловсролын яамны Боловсролын судалгааны Үндэсний хүрээлэнгийн захирал П.Оюунаа, Боловсролын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Бадамжав, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Лхагвасүрэнгийн Мөнхзул, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн газрын дарга Б.Алимаа, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Ю.Отгонбилэг, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батмөнхийн Насантогтох, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Бямбасүрэнгийн Даваацэрэн, Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын зөвлөх Ж.Эрхэмтөгс, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга Мянгаагийн Баяраа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Төмөрхуягийн Жамбалцэрэн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр

орлон гүйцэтгэгч Чулуунцэцэгийн Золбаяр, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга Цэнджавын Борхүү, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Батмөнхийн Ерэн-Өлзий, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Дагвадоржийн Очирбат, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга Шаравын Мөнхцэрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Болдын Цэнгэл, “Эрдэнэс Монгол” компанийн гүйцэтгэх захирал Санжаагийн Наранцогт, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга Анандын Энхманлай, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Батаагийн Батцэцэг, Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын зөвлөх Булгаагийн Ганбат, Шинжлэх ухааны академийн академич Агипарын Бакей, Шинжлэх ухааны академийн академич Сүхрагчаагийн Нямзагд, Шинжлэх ухааны академийн академич Дамдины Дагвадорж, Шинжлэх ухааны академийн академич Түвдийн Дорж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр төслийн Үр дүнд суурилсан төлөвлөлтийн зөвлөх Ганхуягийн Цэрэнжаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Хаш-Эрдэнийн Сүрэнхорол, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Лхагвабаярын Энх-Амгалан, Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Батболдын Мөнхтөр, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Бат-Ирээдүйн Анар, Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Төмөрийн Баясгалан, Эдийн засаг, хөгжлийн яамны Бизнесийн орчны бодлогын газрын дарга Лхагвасүрэнгийн Балчинлуvsан, Эдийн засаг, хөгжлийн яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Даринчулууны Эрдэнэтуяа, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Мижиддоржийн Санжаадорж, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Жамъяншаравын Дэлгэржаргал, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Ганболдын Золбоо, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Солонгийн Тулга, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Батчулууны Мөнгөнсүх, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Тогтвортой хөгжлийн нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Пүрэвдоржийн Чандмань, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Батжаргалын Төгөлдөр, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын ахлах шинжээч Доёддоржийн Сугар, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Зияханы Райымбек, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Галиндэвийн Отгонцэцэг, Зам, тээврийн яамны Авто замын бодлого зохицуулалтын газрын дарга Чадраабалын Сугармаа, Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ганбадраагийн Батбаяр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын

хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Аюурзанын Энх-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Ганзоригийн Эрдэнэбулган, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга Ганбаатарын Энхтүвшин, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Батмөнхийн Пунцагбалжир, Хилийн боомтын захиргааны дарга Батдэлгэрийн Батхишиг, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газрын дарга Дэмбэрэлийн Энхбаатар, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газрын дарга Мэдэхгүйн Ням-Очир, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Батцэцэгийн Уянга, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газрын дарга Оюуны Одбаяр, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Бямбасүрэнгийн Туяа, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Энэбишийн Оюунсүрэн, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Их өгөгдөл, судалгааны албаны дарга Ганзоригийн Дамба, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Дашдондовын Булгантамир, Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгслийн газрын дарга Намжилын Эрдэнэбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Цэндгомбын Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч Дангаасүрэнгийн Баярсайхан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Тогтохжаргалын Золбаяр, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Ойн газрын дарга Бямбасүрэнгийн Оюунсанаа, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Сугарын Эрдэнэцэцэг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Даваацэрэнгийн Дэчин, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Аж үйлдвэрийн бодлогын газрын дарга Медсчогийн Мэндбаяр, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга Бямбажавын Нандинболор, Хил хамгаалах ерөнхий газрын дарга Жамсрангийн Бямбасүрэн, Хил хамгаалах ерөнхий газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Цэрэндагвын Чойжилсүрэн, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Довдонгийн Давааням, Шүүх шинжилгээний ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга Болдын Амар, Цагдаагийн Ерөнхий газрын Тэргүүн дэд дарга Бэхбатын Ганчулуун, Цагдаагийн Ерөнхий газрын Дэд дарга Одоохоны Ганбат.

Ажлын хэсэг танилцуулж дууслаа.

Тогтоолын төслийн талаар хууль санаачлагчдаас асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Г.Очирбат гишүүнээр тасаллаа.

Ирцийн дагуу болсон уу. Тийм ээ. Болдын. Уянга гишүүн.

Б.Уянга: Өдрийн мэнд хүргэе. Хэд хэдэн чиглэлээр 2026-2030 оны үндсэн чиглэлийн төлөвлөгөө, тогтоолын төслийг үзлээ.

Тэгээд асуух асуултууд бас нэлээд байна.

Хамгийн эхлээд төрийн өмчит компаниуд их олон байгаа. Бид хувьчилна гэж ярьж байгаа.

Тэгээд мэдээж зарим зүйл дээр төрийн өмчийн оролцоо заавал байх ёстой байдаг байх. М.Энхцэцэг гишүүн бас энэ эрчим хүчний дамжуулах сүлжээ, тэр хэсгүүд нь төрийн өмчит байх ёстой гэж нэлээн ярих юм.

Тэгэхээр нэг тийм тоотой, хувьтай хэлээд өгөөч.

→ Хэчнээн төрийн өмчийн эзэмшлийн компани байгаа юм?

→ Хэдийг нь 2030 он гэхэд хувьчлах юм?

7 дугаар бүлэгт төлөвлөгөөнд төрийн өмчит компаниудтай холбоотой хэсгүүд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр орсон байна. С.Бямбацогт сайд байгаа юм чинь өөрөө хариулаад өгөөрэй.

Байгаа зүйлүүд нь 7.3.5 дээр “төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулна”, “олон улсын компанийн жишигт хүргэнэ”. Бууруулна гэдэг агуулга байдаггүй.

Төрийн болон орон нутгийн өмчийн үр ашгийг нэмэгдүүлнэ, хариуцлагыг нэмэгдүүлнэ гэсэн байна. Хариуцлагыг нэмэгдүүлэхээр эсвэл бас хувьчилна гэсэн агуулга нь оров уу?

Төрийн болон орон нутгийн өмчийн харилцааны бүртгэл мэдээллийн ил тод байдлыг бүрэн хангана гэсэн байна.

Тэгэхээр 2030 он гэхэд төрийн өмчтэй холбоотой ийм заалтууд суужээ.

Тэгэхээр үүнтэй холбоотой төрийн өмчийн компаниудыг хэдэн хувийг нь хэзээ, яаж хувьчлах вэ гэдэг дээр хариулт авъя.

▷ **Хоёрдугаарт нь**, уул уурхайн салбарын тогтвортой байдлыг хангахын тулд хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах замаар салбарыг хөгжүүлнэ гэсэн байна. Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг яг яаж хамгаалах вэ? Яг юу юу төлөвлөж байна?

Уул уурхайтай холбоотой хоёр дахь том зорилт нь ашиглагдаж байгаа ордуудын хүчин чадлыг нэмэгдүүлээд, нөөц нь тогтоогдсон ордуудыг эргэлтэд оруулна гэсэн байна.

Уул уурхайтай холбоотой хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах талаар хоёр дахь асуултдаа хариулт авъя.

Ч.Лодойсамбуу: Н.Учрал сайдын микрофоныг өгье.

Н.Учрал: Энэ удаагийн таван жилийн үндсэн чиглэлийн гол зорилго бол үр дүнг тодорхойлсон. Тэгээд яг индикаторуудаа тавиад явж байгаа.

Тэгэхээр ирэх жилээс бид мониторинг хийхдээ индекс, эрэмбэ, хувь өссөн үү, үгүй юу гэдэг дээр л үнэлэлт дүгнэлт өгнө. Нэг ёсондоо бид **“чанарын арга”** гэхээсээ **“тоон арга”**-аар илүү их хэмжиж байна.

Тийм учраас **SDG¹** (Sustainable Development Goals)-ийн зорилтуудыг уялдуулсан. Мөн салбар болгон дээр яг өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлоод индекс урагшилж байна гэдгийг хэмжиж байгаа.

Тийм учраас төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг цаашдаа хувьчлах, нэгтгэж нийлүүлэх, өөрчлөн зохион байгуулах ажлууд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр хийгдээд явна.

Үндсэн чиглэлийн төслийн 3 дугаар хавсралтын 7.3.5 дээр компанийн засаглалын үнэлгээний дунджийг тооцдог болох зорилтыг дэвшүүлээд ирэх 5 жилд тооцсон түвшнээс 3 хувиар нэмэгдүүлнэ гэж байгаа юм.

Тэр 3 хувь дээр нь ямар ямар нэгж хувиар нэмэгдүүлэх вэ гэдэг дээр нь жил болгон дээр түвшинг нь тавиад явсан. Ингээд төсвийн ерөнхийлөн захирагч ямар үр дүнд хүрэх вэ гээд. Жишээ нь, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр яг энэ индикаторуудыг нь тавиад дэмжээд явж байгаа гэсэн үг.

Тэгэхээр –

- салбарын үр дүн,
- үндэсний үр дүн,
- төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн -

хоорондоо нийцэж байгаагаараа **“хөгжлийн бодлого”**, **“таван жилийн чиглэл”**-ийг боловсруулж байгааг салбарын сайдын хувиар хэлье.

Энэ дээр нэмэлт мэдээллийг мэдээж С.Бямбацогт сайд өгөх байх. Бид ингээд хэмжээд явна.

Хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах чиглэлээр 1993 онд Гадаадын хөрөнгө оруулалтын хуулиар зохицуулж байсан харилцааг 2013 оноос Хөрөнгө оруулалтын хуулиар зохицуулдаг болсон.

¹ НҮБ-аас баталсан 2030 он хүртэлх "Тогтвортой хөгжлийн зорилтууд"-тай Монгол Улсын хөгжлийн таван жилийн үндсэн чиглэл, зорилтуудыг уялдуулсан.

Бид Хөрөнгө оруулагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, гомдол маргаан шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр Эдийн засгийн эрх чөлөөний анхдагч хуулийн төслийг дагуулаад Хөрөнгө оруулалтын хуулийг өргөн мэдүүлэх гэж байна. Засгийн газраар гурав дахь өдөр танилцуулна. Хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах чиглэлээр үндсэн чиглэлийн 3 дугаар хавсралтаар Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэсэн байдал 2024 онд 25 хувь байсан юм билээ. Үүнийг 2030 онд 100 хувьд хүргэнэ гэдэг зорилт дэвшүүлж байгаа. Ирэх жил хэдэн байраар ахих вэ гээд.

Тэгэхээр хөрөнгө оруулалтын асуудлыг эрхэлж байгаа төрийн захиргааны төв байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч хэрвээ энэ хувийг ирэх жил энэ хувиар нэмэгдүүлэхгүй бол хариуцлага ярьдаг тогтолцоо руу шилжинэ.

Тэгэхээр 2030 онд үүнийг 100 хувьд хүргэнэ. Үүнийг хийхийн тулд Эдийн засаг, хөгжлийн яам Хөрөнгө оруулалтын хуулиа боловсруулж батлуулах ёстой.

Тэгэхээр бид энэ чиг үүргээ биелүүлэх хүрээндээ Хөрөнгө оруулалтын хуулийг маргааш Засгийн газар дээр танилцуулах гэж байна. Энэ хөрөнгө оруулалтын хуулиар нэгд бид гомдол маргааныг шийдвэрлэх тогтолцоог шуурхай, оновчтой болгох чиглэлээр гомдол, маргааныг шийдвэрлэх урьдчилсан шийдвэрлэх тэр механизмыг энэ хуулиар хийж өгч байгаа.

Тийм учраас хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах асуудал нэгдүгээрт байна.

Дээрээс нь хөрөнгө оруулалтын бодлого өөрөө Эдийн засаг, хөгжлийн яаман дээр байдаг агентлаг нь хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн Шадар сайд дээр байдаг. Гэхдээ энэ Хөрөнгө оруулалтын агентлаг, нөгөө Монополын эсрэг газар. Ингээд энэ холбогдох байгууллагууд ямар чиг үүрэг хүлээх вэ гэдгийг хуулиар тодорхой болгож өгч байгаа.

Тэгэхээр ирэх жил Та бүхэн үнэхээр хөрөнгө оруулалтын гомдол маргаан шийдвэрлэсэн байдал 2024 онд 25 хувь байтал яагаад 4 хувиар өсөх өсөхгүй байгаа вэ. Энэ дээрээ үнэлэлт дүгнэлт хийгээд хэрвээ хариулахгүй ажиллаж байвал төсвийн ерөнхийлөн захирагч нартаа тэр хувьд хүрэхгүй л бол хариуцлага яриад явдаг ийм механизм руу бид шилжиж байгаа учраас энэ жилийн таван жилийн чиглэл “тоогоор хэмжиж болохуйц” байдлаар хийсэн гэдгийг хэлье.

Ч.Лодойсамбуу: С.Бямбацогт сайдын микрофоныг өгье.

С.Бямбацогт: Б.Уянга гишүүний асуултад хариулъя.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсад нийтдээ төрийн өмчийн 104 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. 60 орчим мянган ажилтан ажиллаж байгаа. Орон нутгийн өмчит нийтдээ 350 компани үйл ажиллагаа явуулж байгаа. Энд нэг 20-иод мянган ажилтан ажиллаж байгаа.

Төрийн өмчит компаниудын хөрөнгийн хэмжээ 58 орчим их наяд төгрөгийн хөрөнгөтэй. 2024 оны жилийн эцсийн байдлаар 25 их наяд, 26 их наяд орчим төгрөгийн орлого олсон. 5 их наяд 800 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байгаа.

Үүнийг 2023 онтой харьцуулаад үзэх юм бол 10 хувиар орлого нэмэгдсэн. Цэвэр ашгийн хэмжээ 15 хувиар нэмэгдсэн. Ерөнхийдөө иймэрхүү дүн гарч байгаа.

Мэдээж үйл ажиллагааг сайжруулах, бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийх тодорхой ажлууд хийгдэж байгаа. Энэ дээр Улсын Их Хурлын өргөн барьсан орон нутгийн... /минут дуусав/

Ч.Лодойсамбуу: С.Бямбацогт сайд гүйцээгээд хариулъя.

С.Бямбацогт: Улсын Их Хуралд бид Нийтийн өмчийн тухай хууль өргөн барьсан байгаа.

Мөн Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хууль өргөн барьсан байгаа. Энэ хуулиудыг Улсын Их Хурал яаралтай хэлэлцээд батлаад өгөх юм бол үүнтэй холбоотойгоор томоохон өөрчлөлтүүд хийгдэнэ. Үүнтэй холбоотой.

Мөн өмч хувьчлалын хүрээнд 2026-2028 онд Монгол Улсын өмч хувьчлах үндсэн чиглэлийг Улсын Их Хуралд энэ намрын чуулганаар өргөн барина. Ингээд үндсэндээ ирэх хоёр, гурван жилийн хугацаанд ямархуу төрийн өмчит компаниудыг хэрхэн яаж хувьчлах вэ гэдэг бодлогоо Засгийн газраас боловсруулж оруулна.

Улсын Их Хурал тэр бодлогыг баталж өгөөд, үүн дээр тулгуурлаж цаашдаа төрийн өмчит ямар компаниуд хэрхэн яаж хувьчлах вэ гэдэг асуудлууд яригдана.

Ер нь төрийн өмчит компанийн бүтээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг сайжруулах, зардлыг бууруулах, ил тод нээлттэй болгох энэ чиглэлээрээ тодорхой ажлууд хийгдээд явж байгаа.

Мөн цомхон болгох энэ ажил хийгдээд явж байгаа гэдгийг танд хэлье.

Ч.Лодойсамбуу: Б.Уянга гишүүний асуулт дээр нэмээд асууя.

Энэ тараагдсан материал, бид нарт байгаа үндсэн чиглэл, төлөвлөгөө дээр хувьчлалын тухай үг, үсэг байхгүй л байна лээ. Би дутуу харсан уу? Төрийн өмчит компаниудын үйл ажиллагааг сайжруулна гэж байгаа юм.

Тэгэхээр С.Бямбацогт сайд ирэх онд бид хувьчлалын асуудлуудыг өргөн барина гэж байна.

Тэгэхээр бид төлөвлөгөө, чиглэл дээрээ тусгаад явахгүй юм уу? Явахгүйгээр тэгээд явах боломжтой юу гэдгийг асууя. Н.Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Тийм. Таван жилийн чиглэл Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын хуулийн дагуу “удирдамж” гэсэн үг. Ер нь хаашаа явж байна вэ л гэдгээ тодорхойлдог.

Түүнээс биш төсөл, арга хэмжээнүүдийг нарийвчилж мэдээж шууд заадаггүй. Гэхдээ үндсэн чиглэлийн төсөл дээр нөгөө “компанийн засаглалыг сайжруулах” гэдэг агуулга яваад “төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах” гэдэг байдлаар тусаад тэр дундажийг таван жилд тооцсон түвшнээс 3 хувиар нэмэгдүүлнэ гэдэг ерөнхий чиглэл ордог.

Ингээд таван жилийн бодлогын чиглэл нөгөө сонгуулийн циклийн үед биш, энэ чинь 2030 он хүртэл хэрэгжих учраас 2028 оны парламентын сонгуулийн дараа шинээр байгуулагдах Засгийн газар 4 жилийн хөтөлбөрөө боловсруулаад түүнд нь нийцсэн жилийн төлөвлөгөөндөө төсөл, арга хэмжээнүүдийгээ бичээд явдаг учраас энэ бол нөгөө “удирдамж” гэдэг хэлбэрээр буюу нарийвчилсан зохицуулалтыг бас тусгадаггүй гэдгийг хэлье.

Ч.Лодойсамбуу: Тийм. Тэгээд нөгөө удирдамж дээрээ энэ хувьчлалынхаа асуудлыг яг энэ “засаглалыг сайжруулна” гэж байгаа шигээ зүгээр оруулах боломжтой юу л гэж асуугаад байгаа юм. Боломжтой бол оруулаад батлаад явбал.

Тэгэхгүй бол энэ Засгийн газрын гол өмнөө тавьж байгаа гарчиг бол “авлига, хулгайтай тэмцэнэ” гээд байгаа. Авлига, хулгай бол төрийн өмч дээр л байгаа.

Тэгэхээр төрийн өмчийг хэрхэн багасгах вэ, бодлогын хувьд илүү үр ашигтай болгох вэ гэдэг нь засаглалыг сайжруулах биш хувьчлалын тухай Б.Уянга гишүүн асуугаад байна л даа. Н.Учрал гишүүн.

Н.Учрал: Тийм. Ер нь “засаглал сайжруулна” гэдгийн нэг хэлбэр нь –

- хувьчлах,
- нээлттэй болгох,
- нэгтгэх,
- өөрчлөх,
- зохион байгуулах,
- дуудлага худалдаагаар худалдах ч гэдэг юм уу.

Энэ бол нөгөө засаглал сайжруулахын нэг хэлбэр.

Тэгэхээр засаглал сайжруулах түвшинг ахиулна гэвэл хүссэн хүсээгүй –

- хувьчлах,
- нэгтгэх үү,
- өөрчлөх үү,
- зохион байгуулах уу,
- нээлттэй болгох уу гэдэг яригдана.

Тэгээд энэ чиглэл дотор “засаглал сайжруулах түвшинг ахиулах”-ын тулд зарим төрийн өмчит компанийг хувьчлах асуудлаа яриад эхэлнэ гэдэг нь улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөн дээрээ тусгаад явдаг.

Дээрээс нь одоо яг парламент баталсан байгаа дөрвөн жилийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр нөгөө төрийн өмчит компаниудыг нээлттэй болгох, өөрчлөн зохион байгуулах, хувьчлах асуудал тухайлан туссан. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд ч туссан. Сая С.Бямбацогт сайдын хэлж байгаагаар хууль батлагдсаны дараа Засгийн газраас төрийн өмчит компани дээр баримтлах үндсэн чиглэл орж ирэхэд түүнийг дагалдуулаад тогтоолоор аль аль компанийг хувьчлах вэ, нээлттэй болгох вэ гэдэг нь орж ирнэ.

Ч.Лодойсамбуу: С.Бямбацогт сайд нэмээд хариулъя.

С.Бямбацогт: Сая Н.Учрал сайд ерөнхийд нь хариуллаа.

Бодлогын бичиг баримтууд, төрийн бодлогын бичиг баримтууд –

- урт хугацааных,
- дунд хугацааных,
- богино хугацааных гээд тус тусдаа байгаа.

➔ “Алсын хараа-2050” бол урт хугацааны бодлогын бичиг баримт. 30 жилийнх.

Бид Монгол Улсыг хөгжүүлэх үндсэн чиглэлүүдийг батлах ёстой. Хөгжлийн зорилтот 8 хөтөлбөр батлах ёстой. Энэ нь 10 жилийн хугацаатай. Үүнээс бид 1-ийг нь баталсан. 7-г нь батлаагүй байгаа.

- ➔ Таван жилийн үндсэн чиглэл дунд хугацааных.
- ➔ Дөрвөн жилийн Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр богино хугацааных, жилийн төлөвлөгөө богино хугацааных.

Ингээд энэ болгон дээрээ харилцан уялдаатай хоорондоо нарийвчлаад задраад явж байгаа.

Сая би хэлсэн. Төрийн болон орон нутгийн өмч компанийн тухай хууль, Нийтийн өмчийн тухай хууль, өмч хувьчлалын асуудлууд үндсэндээ энэ богино

хугацааны бодлогын бичиг баримтууд, хууль эрх зүйн зохицуулалтууд учраас энд тусгагдаагүй байгаа.

7.3.5.1 дээр бас төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх, төрийн болон орон нутгийн өмчийн үр ашгийг нэмэгдүүлэх гээд сая ярьсан компанийн засаглалыг сайжруулах дээр нэмээд ийм... /минут дуусав/

Ч.Лодойсамбуу: Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуултаа асууя.

Л.Соронзонболд: Гишүүдийнхээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Тэгэхээр таван жилийн төлөвлөгөө дээр эцэст нь Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээнд эзэлж байгаа салбаруудын хувийн жин яаж өөрчлөгдөх юм бэ гэдгийг үндсэн чиглэлд тусгаж оруулах боломжтой байсан уу?

Нөгөө талаасаа бүс нутгуудын дотоодын нөхдүүдэд эзэлж байгаа хувь хэмжээ, мөн түүний бүтэц яаж өөрчлөгдөх юм бэ гэдэг талаар яаж туссан бэ гэж тодруулж асуумаар байна.

▷ **Хоёрдугаарт,** инфляцтай холбоотой асуулт байгаа юм.

10 сарын инфляцыг харахаар 9 хувь болоод өссөн. Энд Монгол Улсын өөрийнх нь дотоодоосоо хамаарч байгаа инфляцын хувь хэмжээ бараг 70 орчим хувь болсон харагдаад байгаа юм.

Өөрөөр хэлбэл төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээ буюу –

- цахилгаан эрчим хүчний үнэ,
- дулааны үнэ,
- шатахууны үнэ.

Дээрээс нь дотооддоо үйлдвэрлэж байгаа хүнсний үнэ, дотоодын бараа үйлчилгээний үнэ 70 хувийг бүрдүүлж байна.

Тэгэхээр ирэх 5 жилд ялангуяа Эдийн засаг, хөгжлийн яамнаас инфляцыг хянаж, салбар хоорондын дунд зохицуулалт хийх талаар ямар бодлогын арга хэмжээг таван жилийн төлөвлөгөө дээр тусгаж байгаа вэ гэж асуумаар байгаа юм.

Тэгэхээр нийлүүлэлтийн гаралтай инфляцыг хянаад, үүнтэй холбоотой бүтээгдэхүүн, үйлчилгээ болгон дээр нь тодорхой хэмжээнд салбар хариуцсан яамдад нь үүрэг, чиглэл өгч ажиллаж, үүнийг сайжруулах талаар ямар төлөвлөгөө тусаж байна вэ гэдэг ийм асуулт байгаад байна.

▷ **Гуравдугаарт,** цомхон, чадварлаг, бүтээмжтэй төрийн албыг бий болгоно гээд байгаа юм.

Тэгэхээр төрийн албан хаагчдын тоо ирэх таван жилийн хугацаанд ямар байдлаар төлөвлөгдөж байгаа юм? Яаж бүтээмжийг нь нэмэгдүүлэх гээд байгаа юм бэ? Энэ талаар тайлбарлаач.

- **Дөрөвдүгээрт**, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024, 2025 оны байдлыг харахаар ер нь нэлээн анхаарах асуудал байна гэж харж байгаа юм.

Тэгэхээр яг энэ Эрүүл мэндийн даатгалын сантай холбоотойгоор ирэх таван жилд яг ямар том бүтцийн өөрчлөлт хийх, бодлогын арга хэмжээ авах гээд байгаа юм бэ?

Хамтын төлбөрийн тогтолцоог бий болгоно гээд байдаг. Гэтэл хамтын төлбөрийн тогтолцооны үр дүнд Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын хэдэн хувь нь хамтын төлбөрөөс бүрдэж байгаа юм? Ирэх таван жилийн хугацаанд хэд болж өөрчлөгдөх юм? Энэ нь Эрүүл мэндийн даатгалын салбарын ажиллагсдын цалин хөлс, эмнэлгийн үйлчилгээний төлбөр, эмийн сангийн зардалдаа хангалттай хүрэх юм уу? Энэ талаар таван жилийн төлөвлөгөөнд яаж туссан бэ гэсэн асуултуудыг асууя.

Ч.Лодойсамбуу: Н.Учрал сайд асуултад хариулъя.

Асуулт асуух гишүүдийн нэрс дээр М.Мандхай гишүүний нэрийг нэмээрэй.

Н.Учрал: Тийм. Таван жилийн бодлогын үндсэн чиглэл өөрөө 8 зорилтот хөтөлбөрөө дотор нь багтаагаад оруулж ирж байгаа.

Тэгэхээр бид хөгжлийн бодлогын маш олон бичиг баримтууд хуулиар өргөн мэдүүлэх үүрэгтэй. Тэгэхээр энэ таван жилийн бодлогын чиглэл төлөвлөгөө гэхээсээ илүүтэйгээр яг аль зүг рүү явах вэ гэдэг чиглэл, удирдамж гэж ойлгож болно. Энэ хүрээндээ инфляцтай холбогдуулсан зохицуулалтууд, индекс, индикаторуудтайгаа холбоод оруулж ирсэн.

Жишээ нь, 3 дугаар хавсралт дээр Та бүхэн харвал 2030 он гэхэд инфляцыг 5 хувийн тогтвортой түвшинд хадгална. Энэ хүрээнд –

- эрэлтийн гаралтай инфляцыг 5,
- нийлүүлэлтийн шалтгаантай инфляцыг 5,
- хүнсний барааны үнийн өсөлтийг 6,
- импортын барааны үнийн өсөлтийг 4 болгоно гэсэн чиглэл оруулсан.

Тэгэхээр үүнийг Эдийн засгийн яам, Сангийн яам, мөн төсвийн бусад ерөнхийлөн захирагч нарыг оролцуулаад энэ тоонуудыг гаргасан байгаа.

Тэгэхээр мэдээж Засгийн газрын өр дээр хүртэл хязгааруудыг тавих ёстой.

Тийм учраас бид Засгийн газрын нийт өр нийт GDP-ийнхээ бараг 60 хувь байгааг 45 руу буулгах ёстой.

Тийм учраас буулгах зорилтыг жил жилээр нь хэд хэдэн хувиар, хэдэн хэдэн нэгж хувиар буулгах вэ гэдгийг нь тавиад төсвийн ерөнхийлөн захирагч нарын үр дүнтэй нь уяад тавьсан гэсэн үг. Тэгэхээр эргээд хариуцлага ч гэсэн яг энэ тоон үзүүлэлтэд яагаад буулгаагүй вэ гэдэг дээр бид хариуцлагаа яриад явахад хэмжихэд их амар болно гэж бид ойлгож байгаа.

Тийм учраас яг энэ инфляцтай холбогдуулаад тоон хэм хэмжээсүүд шууд шууд тавигдаад явсан. Энэ хүрээнд бид мэдээж Эдийн засаг, хөгжлийн яам төсвийн хүрээгээ өргөн мэдүүлээд ажиллаж байгаа учраас хүрээ хязгаар, тоон дээрээ хязгааруудаа хатуу бариад явахад тодорхой үр дүнд хүрнэ.

Зүгээр инфляц дээр Монголбанк зорилтот интервалаа тодорхойлдог. Монголбанкны зорилтот интервалын түвшинд инфляцыг бид хадгалаад явж байгаа. Тэгээд мэдээж Монголбанк 4-өөс 8 хувийн интервалд байлгахаар зорьж байгаа.

Тэгэхээр бид энэ дээр бодлогын тохируулгуудаа хийгээд цаашид 2027 оноос 5 хувь дээр хадгалаад явна. Энэ зорилтоо тогтооно гэдэг байдлаар явсан. Тэгэхээр жил болгон нэгж хувиар бууруулах үүргийг төсвийн ерөнхийлөн захирагч нар хүлээж байгаа гэдгийг хэлье.

Төрийн албатай холбогдуулаад С.Бямбацогт дарга хариулна. Эрүүл мэндийн даатгалын сан хоёрыг.

Ч.Лодойсамбуу: С.Бямбацогт сайдын микрофоныг өгье.

С.Бямбацогт: Таван жилийн үндсэн чиглэлд төрийн албатай холбоотой тодорхой заалтууд тусгасан байгаа. Чадавхуйн зарчимд суурилсан, оновчтой, чиг үүрэг бүтэц бүхий цомхон чадварлаг төрийн албыг бэхжүүлнэ гээд.

Өнөөдөр Монгол Улсын хэмжээнд төрийн албанд нийтдээ 230 орчим мянган албан хаагч ажиллаж байгаа. Үүнээс –

- | | |
|----------------|---------------------------------|
| ➤ 21 мянга нь | -төрийн захиргаанд, |
| ➤ 50 мянга нь | -төрийн тусгай, |
| ➤ 152 мянга нь | -төрийн үйлчилгээ, |
| ➤ 3800 нь | -улс төрийн албан хаагч байгаа. |

Сүүлийн 10 жилийн байдлаар аваад үзэхэд –

- | | |
|----------------------|------------|
| ➤ төрийн албан хаагч | 17 хувиар, |
| ➤ төрийн захиргаа | 8 хувиар, |
| ➤ төрийн үйлчилгээ | 20 хувиар, |
| ➤ төрийн улс төр | 19 хувиар, |

➤ төрийн тусгай албан хаагчдын тоо 27 хувиар нэмэгдсэн байгаа.

Тийм болохоор бид илүү цомхон, чадварлаг, бүтээмжтэй төрийн албыг бий болгоё. Төрийн албан хаагчдын нэр хүнд мэдлэг чадвар, ёс зүй дээр тулгуурлах ёстой. Энэ рүү чиглэсэн томоохон... /минут дуусав/

Ч.Лодойсамбуу: С.Бямбацогт сайдын микрофоныг нэмж өгье.

С.Бямбацогт: Энэ рүү чиглэсэн томоохон бодлого хийж хэрэгжүүлнэ гэж байгаа юм. Гол ажил бол ажлаа хийж чадаж байгаа хүмүүсийг ямар нэг улс төрөөс хараат бус, хэн нэгнээс хамааралгүйгээр ажлаа хийх бололцоо боломжийг бүрдүүлье.

Өнөөдөр даргын үзэмжээр ажилд томилогддог, даргын тийм үзэмжээр ажлаас халагддаг, даргын үзэмжээр ажил нь үнэлэгддэг гүйцэтгэлийн үнэлгээг нь хамааралгүй болгоё. Иргэдийн оролцоотой, иргэдийн хяналт доор, иргэдээрээ үнэлүүлдэг байх. Өөрөөр хэлэх юм бол байгууллага дотор ажиллаж байгаа албан хаагч нарыг дарга үнэлдэг биш иргэд үнэлдэг, үнэлсэн үнэлгээ нь олон нийтэд ил тод байдаг. Ийм болох юм бол энэ хэмжээгээрээ үндсэндээ төрийн албан хаагчдын ёс зүйн мэдлэг, ур чадвар дээшлэх, илүү хариуцлагатай байх зарчим бий болно гэж үзэж байгаа.

Ийм байдлаар үндсэндээ чадахуйн зарчимд суурилсан оновчтой чиг үүрэг, бүтэц бүхий болгоё. Мөн төрийн албаны сургалтуудыг илүү чанартай... /минут дуусав/

Ч.Лодойсамбуу: С.Бямбацогт сайдын микрофоныг нэмж өгье.

С.Бямбацогт: Эрүүл мэндийн даатгалын сангийн үйл ажиллагаа үндсэндээ эмнэлгүүд дээр гүйцэтгэлийн үнэлгээгээр санхүүжилтийг олгодог болсонтой холбоотой бодлого нь зөв байсан. Хэрэгжүүлэхдээ маш сайн төлөвлөж, зохион байгуулж, хяналт тавьж хэрэгжүүлээгүйгээс болоод үндсэндээ томоохон алдаа дутагдал гарсан байгааг сая шалгалтаар ил тод болж гарч ирж байгаа.

Хууль зөрчсөн, хөрөнгө завшсан, эрүүл мэндийн даатгалын санг алдагдалтай болгосон асуудлуудыг хууль хяналтын байгууллагуудад шилжүүлсэн.

Энэ дээр томоохон бодлогын өөрчлөлт хийх шаардлагатай болж байна. Бодлого нь зөв мөртөө тэр зөв бодлогоо төлөвлөж зохион байгуулж хэрэгжүүлэхдээ л алдаа гарсан. Энэ алдааг хууль эрх зүйн хүрээнд, дээрээс нь Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн хүрээнд, цаашлаад Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын хүрээнд нэлээн цогцоор нь авч үзэх шаардлагатай. Ингэх юм бол боломж, бололцоо байгаа юм билээ.

Ч.Лодойсамбуу: Л.Соронзонболд гишүүн тодруулъя.

Л.Соронзонболд: Энэ инфляцтай холбоотой асуудал яриад байгаа нь нөгөө зээлийн хүүг бууруулъя гээд яриад байдаг. Гэтэл нөгөө инфляц маань өндөр байгаад байхаар зээлийн хүү нь буурч өгөхгүй байгаа юм.

Монгол Улсад инфляцыг хэмждэг, хянадаг байгууллагууд нь байгаад байдаг. Яг нөгөө сагсанд байгаа 330 бүтээгдэхүүнээ хувааж аваад яамдаар нь хуваарилаад, тэгээд тэр тухайн яамдын барьж байгаа бодлогоос хамаараад тухайн бүтээгдэхүүнүүд бараа, үйлчилгээний үнэ ер нь цаашдаа яахаар байгаа юм бэ гэдгийг нь төсөөллөө гаргаж явдаг ажлыг Эдийн засаг, хөгжлийн яам хийхгүй бол бид үүнийгээ яриад л яваад байгаа юм. Зөвхөн Монголбанк зээлийн хүүгээ өсгөөд, мөнгөний хатуу бодлогоо бариад ч юм уу, инфляцыг барина гэж байхгүй.

Тийм учраас энэ дээр ялангуяа Эдийн засаг, хөгжлийн яаман дээр анхаарч ажиллах шаардлагатай. Ялангуяа хөгжлийн бодлого, төлөвлөлтдөө энэ чиглэлээр Эдийн засаг, хөгжлийн яамны бүтцийн хүрээнд байх юм уу, Засгийн газрын түвшиндээ байх юм уу ямар ч байсан энэ талаар салбар хоорондын уялдааг нь хангаж хянадаг ийм бүтэц шаардлагатай байна гэж би өөрөө үзээд байгаа юм. /минут дуусав/

Ч.Лодойсамбуу: Л.Соронзонболд гишүүн үг хэллээ. Мөнхчулууны Энхцэцэг гишүүн асуулт асууя.

М.Энхцэцэг: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Монгол Улсыг ирэх таван жилд хөгжүүлэх үндсэн цэг чиглэлийг хэлэлцэж байна.

Тэгэхээр үндсэн чиглэлийг боловсруулахдаа зорилго, зорилтоо хэмжигдэхүйц байдлаар боловсруулсан нь сайшаалтай байна. Гэхдээ эрчим хүч талдаа шүүмжлэлтэй хандах нэлээд олон асуудлууд байна. Яагаад гэхээр энэ бичиг баримтаас бүхэл бүтэн Монгол Улсын эрчим хүчний салбарыг ирэх таван жилд хөгжүүлэх тэр бодлого, чиглэл харагдана гэж хүлээлттэй байсан.

Гэвч тэр төдийлөн сайн харагдахгүй байна. Нөгөө л улиг болсон хэдэн цахилгаан станцууд, шугамуудаа жагсаасан. Тэгээд төслүүдийнхээ танилцуулгад бүхэл бүтэн нэг нэг хуудас зарцуулсан маш үнэтэй ном хэвлэсэн нэг ийм чиглэлийг хараад сууж байна.

Гэтэл бид сүүлийн жилүүдэд маш их ярьж байгаа. Цахилгаан эрчим хүчний зах зээлээ либералчлах шаардлагатай байна. Хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна. Яагаад гэвэл эрчим хүчний салбар бүтэлгүйтээд, хөгжихгүй, улс орныхоо хөгжлийг чөдөр тушаа болоод сууж байгаа гол үндсэн шалтгаан нь өнөөдөр эрчим хүчний салбарт төр монопол буюу хэрэглэгч эх үүсвэр хоёрын дунд төр лаглайгаад суучхаад байгаа тийм систем

юм. Үүнийг явал энэ хоёрын дундаас төрийг холдуулах вэ, зах зээлийг либералчлах вэ гэдэг асуудал их ярьж байгаа.

Гэтэл энэ талаар бүр нэг ширхэг ч үг, өгүүлбэр энэ үнэ хөгжүүлэх гэж байгаа үндсэн чиглэл дотор байхгүй байна. Энэ яагаад вэ?

Зах зээлээ ирэх таван жилүүдэд хэдэн хувийг нь либералчлах юм, чөлөөтэй өрсөлдөөнтэй болгох юм? Ядаж 5 хувь нь, 10 хувь нь гээд энэ дотор чинь орж ирэх ёстой юм биш үү? Хувийн хэвшлийн оролцоо нь хэдэн хувьтай байгаа юм. Энэ таван жилд тэр хувийн хэвшлийн оролцоог хэдэн хувьд хүргэх юм?

Тэгэхээр иймэрхүү байдлаар хөгжлийн чиг хандлага, бодлого чинь энэ тусгагдах ёстой юм биш үү?

Ер нь “Алсын хараа-2050” батлагдахаас өмнө эрчим хүчний салбарт харьцангуй төрөөс баримтлах бодлогын бичиг баримт, сэргээгдэх эрчим хүчний нэгдсэн бодлого, эрчим хүчний хэмнэлтийн бодлого гээд маш сайн бодлогын бичиг баримтууд байсан. Гэтэл “2050” гарч ирээд тэр хөгжлийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх хууль батлагдсанаас болоод өмнө байсан бүх сайн бодлогын бичиг баримтуудыг хүчингүй болгосон.

Тэгээд “Алсын хараа- 2050” гээд бодлогын бичиг баримтыг харахаар бас л нөгөө мөрөөдлийн жагсаалт. Одоо энэ таван жилийн төлөвлөгөө дахиад л нөгөө мөрөөдлийн жагсаалт.

Тэгээд хамгийн харамсалтай нь энэ хуулиар салбарууд өөрсдөө бодлого гаргахыг хориглосон. Үнэхээр гайхалтай.

Тэгээд маш олон улсууд танай бодлого чинь хаана байна гэхээр уучлаарай, бид салбар бодлого гаргахыг хориглосон юм гээд бодлого байхгүй. Салбарууд нь. “2050”-ийг харуул гэхээр зүгээр л нэг мөрөөдлийн жагсаалт.

Тэгээд одоо энэ либералчлал бас яг адилхан... /минут дуусав/

Ч.Лодойсамбуу: Б.Чойжилсүрэн сайд хариулъя.

Б.Чойжилсүрэн: Байнгын хорооны гишүүдийнхээ өдрийн амрыг эрье. М.Энхцэцэг гишүүний асуултад хариулъя.

Яагаад энэ эрчим хүчний салбарын либералчлалыг хувьчилж тавиагүй юм бэ. Үг, өгүүлбэр байхгүй байна гэдэг ийм шүүмжлэл ярьж байна.

Нэгдүгээрт, эрчим хүчний салбарын төрийн өмчит компаниуд дээр ил тод биш байна, засаглал муу байна гэдэг шүүмжлэл байдаг. Энэ ч бас үнэний хувьтай гэдэг шүүмжлэлийг хүлээж авч байгаа.

Би 2022 онд Эрчим хүчний сайд болсноос хойш намайг ажил авч байх үед дандаа алдагдалтай явсан. 2024 оны 11 сарын 15-ны өдөр эрчим хүчний үнийг өртөгт нь ойртуулах нэг арга хэмжээ авсны дараа 2025, 2026, 2027 онуудад эрчим хүчний салбарын компаниудыг ямар ч байсан нь алдагдалгүй ажиллуулах бодлого, зорилт тавьсан.

Энэ жилийн тухайд эрчим хүчний төрийн өмчит 27 компани бий. Нийт ашиг нь 17 орчим тэрбум төгрөгийн ашиг гарахаар төлөвлөгөөтэй байсан боловч Засгийн газрын 132 дугаар тогтоолоор эрчим хүчний үнэ, тарифын өөрчлөлтийг хойшлуулсан учраас энэ жил тухайлбал 196, 200 орчим тэрбум төгрөгийн алдагдалтай гарахаар байна.

Тэгэхээр алдагдалтай ажиллаж байгаа аж ахуйн нэгжүүдийг олон нийтэд санал болгоно гэдэг их төвөгтэй. Үнэгүйдүүлэх магадлалтай байгаа учраас олон улсын хувьчлал явуулдаг сонгодог загвараар нь бэлтгэл хийе гэдэг бодлого нэгдүгээрт тавьсан.

Хоёрдугаарт, манай Монголын эрчим хүчний салбар нэг худалдан авагчийн загвартай байгаа. Нэг худалдан авагчийн загварыг олон худалдан авагчийн загвар луу өөрчлөх хууль, эрх зүйн орчныг Танаар ахлуулсан Улсын Их Хурлын дээр байгуулагдсан ажлын хэсэг хуулийн төслөө өргөн бариагүй байгаа учраас бид энэ талаар тавиагүй байгаа.

Танай ажлын хэсэг хуулийн төслөө боловсруулаад Их Хурлаар батлуулсан тохиолдолд бэлэн байгаа хууль эрх зүйн орчинд энэ таван жилийн төлөвлөгөөг боловсруулахгүй бол таван жил гэдэг маань 2030 онд дуусна. 60-хан сар байдаг.

Улсын Их Хурлын 2024 он байгуулагдаад өнөөдөр 15, 16 сар болсны дараа хуулийн төсөл ч үгүй сууж байгаа үед ийм шинэчлэлийг хийхэд түвэгтэй байсан учраас бид энэ удаа орхигдуулсан.

Энэ жил эрчим хүчний салбарын төрийн өмчит компаниуд дахиад алдагдалтай явна. Нөгөө хувьчлал гэдэг маань дахиад л нэг жилээр хойшлох магадлал өндөр байгаа учраас тавьж чадаагүй гэдгийг зөв ойлгоорой.

Та энэ дээр эрчим хүчний салбараас томилогдсон манай салбарыг бараг төлөөлж байгаа гишүүний хувьд энэ хуулийн төслөө боловсруулах ажил дээр яаравчлаач ээ. Бид бүх техникийн туслалцааг үзүүлнэ, үзүүлсээр ч ирсэн.

Ч.Лодойсамбуу: М.Энхцэцэг гишүүн нэмж тодруулъя.

М.Энхцэцэг: Тэгэхээр ирэх таван жилд цахилгаан эрчим хүчний зах зээлээ либералчлах гэдэг бодлого, чиглэлийг энэ дотор оруулах юм уу, үгүй юм уу? Энд л хариулт өгөөч ээ гэж хүсэж байна.

Хоёрдугаарт нь, “Алсын хараа” дээр ч харахаар зүгээр л нэг мөрөөдлийн жагсаалт. Энэ ч гэсэн адилхан мөрөөдлийн жагсаалт байна. Харахад. Эрчим хүчийг хэн ч харсан тийм байгаа байхгүй юу. Зүгээр нэг жагсаалт.

Тэгэхээр салбар өөрөө тэр нэг бодлого гаргахыг хориглосон байгаа юмаа болиулаач ээ. Яагаад гэвэл алив бодлогын бичиг баримт гэхээр яамнаас тэгээд байгаа байхгүй юу. Байхгүй байхгүй. “Алсын хараа”-г хар. Үүнийг хар. Үүнийг харахаар зүгээр л мөрөөдлийн жагсаалт байгаад байгаа байхгүй юу. Тэгтэл өмнөх бодлогын бичиг баримт харьцангуй сайн байсан юм.

2015-2030 онд Төрөөс эрчим хүчний салбарт баримтлах бодлогын бичиг баримт, Сэргээгдэх эрчим хүчний нэгдсэн хөтөлбөр, Хэмнэлтийн хөтөлбөр гээд тэднийг уншихаар үнэхээр сайн хөтөлбөрүүд. Зах зээлээ яаж либералчлах юм, яаж хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх юм, яаж хэмнэх юм гээд маш сайн бодлогууд суусан байсан юм билээ. Гэтэл тэд нарыг бүгдийг нь хүчингүй болгосон юм билээ.

Тэгэхээр эсвэл тэрийг... /минут дуусав/

Ч.Лодойсамбуу: Н.Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Зах зээлээ хориглосон, хязгаарласан эрчим хүчний олон хууль байна. Энэ хуулиа янзалж өгөөч ээ. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын хууль дээр чинь салбар болгон бодлого боловсруулж болохгүй гэдгийг чинь хуульчилсан.

Энэ таван жилийн чиглэл дээр яаж байна вэ гэхээр эрчим хүчний бие даасан тасралтгүй, найдвартай байдлыг хангаж, эдийн засгийн тэргүүлэх салбаруудын нэг болно гэж үзээд дотор нь импортын хамаарлыг 40 хувиар бууруулна л гэсэн юм. Энэ хүрээнд Эрчим хүчний яам тэр эрчим хүчний хуулиуддаа өөрчлөлт оруулах үүргийг хүлээж байгаа. Импортын хамаарлыг 40 гэж.

Түүнээс биш энэ бол ерөөсөө мөрөөдлийн жагсаалт биш. Энэ бол хэмжиж болохуйцаар хийсэн учраас. Мөрөөдлийн жагсаалт байлгахгүйн тулд таван жилийн чиглэлд индикаторуудыг тавиад хэмжиж болохуйцаар хийсэн юм шүү. Тийм.

Дээрээс нь “засаглалыг шинэчилнэ” гэдэг дотор либералчлах бодлого хамаарагдах ёстой.

Тэгэхээр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиудаа бариад ажилладаг.

Тийм учраас тэр 500, 600 хэрэгтэй хэрэггүй бодлогын баримт бичгүүдээс арай гэж нэг салж байхад салбар болгон бодлоготой бол гээд яриад байх нь ухралт шүү.

Ч.Лодойсамбуу: Пүрэвийн Батчимэг гишүүн асуулт асууя.

П.Батчимэг: Өнөөдрийн Эдийн засгийн байнгын хорооны хурал өргөн бүрэлдэхүүнтэй, зохих албаны хүмүүс хүрэлцэн ирсэн хурал болсонд хурал даргалагчид талархлаа илэрхийлье.

Цөөн хэдэн зүйл дээр бас асуулт асууя гэж бодож байна.

Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн баримт бичгийн ном бидний гарт ирсэн. Цаг хугацааны хувьд цаглаварын хувьд ялимгүй бас хоцорч орж ирэв үү гэж харж байна. 11 сарын 30-нд Их Хурлаар батлах юм шиг байна.

Тэгээд ер нь 2026-2030 оны үндсэн чиглэлийг Засгийн газар боловсруулахдаа урьд урьдын Засгийн газрын боловсруулж байсан үндсэн зарчмаас ер нь ялгаатай буюу ижил төстэй, ер нь ахиц дэвшил авчрах, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, дундаж давхаргын амьдралын чанар, чансаа, дундаж давхарга өнөөдөр яг байна уу, үгүй юу гэдэг дээр ямар бодлого боловсруулсан юм?

Өнөөдрийн Монголын нийгэм, эдийн засгийн ачааллыг нуруундаа авч явж байгаа аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн байгууллага, жижиг, дунд үйлдэрлэл, бизнес эрхлэгчдийн эрх ашгийг ямар хэмжээнд хүргэх. Тийм ээ.

Тэгээд цаашилбал ер нь хөдөлмөр эрхлэх иргэдийн тоог нэмэгдүүлэх, тэр дундаа тэтгэвэрт гарсан иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, дахин хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тал дээр ямар нэгэн тусгай бодлогын асуудал энд оров уу?

Ер нь Эрүүл мэндийн даатгалын сан, Нийгмийн даатгалын сан үеийн үед Засгийн газар болгоны үед хэл ам дагуулсаар л ирсэн.

Тэгэхээр буруутай хүмүүс, тэр албан тушаалтнуудыг хуулийн байгууллагад шилжүүлээд л чимээгүй орхих юм уу, эсвэл тэдэнд яг тодорхой арга хэмжээ авч, ер нь энэ Эрүүл мэндийн даатгалын санг Эрүүл мэндийн яамнаас тусад нь гаргах асуудал ер нь энэ Засгийн газрын үед байх болов уу гэж асуумаар байна аа.

Тэгээд нийгмийн даатгалын шимтгэлийн асуудалтай холбоотой хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох тал дээр бас л асуудал дагуулж байгаа. Аж ахуйн нэгжүүдэд маш их ачаалал үүрүүлсэн энэ асуудал дээр үндсэн чиглэл ирэх таван жилд ер нь ямар байна.

Ч.Лодойсамбуу: Н.Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Дундаж давхаргыг тооцдог аргачлал байхгүй байгаа юм билээ.

Манайх ер нь дундаж давхаргаа тооцож үзээгүй. Яг ийм аргачлал байхгүй. Статистикууд хоорондоо зөрдөг. Харин олон улсад дундаж давхаргыг тооцсон тогтсон аргачлал байхгүй мөртөө хэд хэдэн хувилбараар тоочиж үздэг юм байна.

Жишээ нь, Дэлхийн хөдөлмөрийн байгууллага дундаж давхаргыг тооцох аргачлал буюу дундаж орлогын 50-иас 150 хувийн интервалд багтах өрхийг дундаж давхаргад тооцож үзэхэд 2018 онд 52 хувь, цар тахлын нөлөөгөөр 42, 2022 онд 40 хувь болсон ч энэ нь 2023 онд буцаад 55 хувьд нэмэгдсэн гэж. Яах вэ энэ аргачлалыг барьсан.

Тэгэхээр бид эхлээд дундаж давхаргыг тооцдог аргачлалаа боловсруулж дуусах нь бидний хувьд тулгамдсан асуудал.

Тэгэхээр ер нь бид таван жилийн чиглэлийг хийхэд олон улсын индексүүдтэй энэ аргачлалуудтай үүнийг нийцүүлэх гэж нэлээдгүй ажил болоод байгаа юм л даа. Төрийн албан хаагч нар чинь өдөр шөнөгүй суугаад, Шинжлэх ухааны академийнхантай хамтраад үзэж тарлаа л даа. Тийм. Тэгээд 126 ширхэг ном л хэвлээд гишүүдэд өгсөн байгаа юм. Тэр нэг их үнэтэй цайтай юм биш. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хэрэгжээд явж байгаа. Тийм.

Тэгэхээр тооцох аргачлалууд хүртэл байхгүй байсан байхгүй юу.

Тийм учраас аргачлалаа боловсруулаад, бид энэ аргачлалынхаа тусламжтайгаар дундаж давхаргын хэмжээг 20 хувиар нэмэгдүүлэх зорилтыг л тавьж байгаа.

Ер нь их даруухан шүү дээ. Түүнээс тийм их том мөрөөдлийн жагсаалт. Түрүүн М.Энхцэцэг гишүүний яриад байгаа юм байхгүй шүү.

Хоёрт, дундаж дагаврыг нь нэмэгдүүлэхэд эдийн засгийн өсөлттэй шууд хамааралтай.

Энэ хүрээндээ бид хэд хэдэн зүйлийг хийнэ. Түрүүн дурдагдаж байгаа. Инфляцыг зорилтот түвшинд хадгална. Монголбанкны зорилтот түвшинд хадгалах бодлого, зорилтыг аль ч, ямар ч үед Засгийн газар байгуулагдсан энэ таван жилийн чиглэлийнхээ дагуу дараах тоон үзүүлэлтүүдийг барина.

Ингээд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хадгална. Тэр 5.1-ээс 6 хувьд хүргэхээр хадгална. Бизнесийн таатай орчин бүрдүүлэх буюу ажиллах хүчний оролцооны түвшин одоо 61.9 байна. Үүнийг 65 хувьд хүргэнэ.

Тэгэхдээ нэгж хувиар таван жилийн тутам өснө гэдгийг нь нөгөө төсвийн ерөнхийлөн захирагч нарын үр дүн дээр нь индикаторуудаар хэмжсэн. Энэ нь тийм их гайхалтай юм биш л дээ уг нь. Энэ хувийн хэвшлийнхэн энэ тэр мэдэж байгаа. П.Батчимэг гишүүн бүгдээрээ л мэдэж байгаа.

Ер нь Монголын том аж ахуйн нэгжүүд угаасаа л “Кей Пи Ай” тавиад л, тэгээд хэмжээд цалин хөлс, урамшуулаад тооцоод явдаг. Бид л нэг их тийм хоцрогдоод байгаа болохоос биш хувийн хэвшил бүгдээрээ л “Кей Пи Ай” үнэлээд л явж байгаа шүү дээ. Энэ нэг их тийм гайхалтай юм биш.

Тэгэхээр бид энэ удаа илүү хэмжиж болохуйцаар хийсэн учраас Та нар ажиллахлах хүчний оролцооны түвшний 65 хувьд хүргэнэ шүү. Үүн дээр салбарын үр юу байх вэ. Аль салбар оролцох вэ, аль төсвийн ерөнхийлөн захирагч нар оролцох вэ гэдгийг нь хатуу тавиад явж байгаа.

Дээрээс нь нөгөө бүлгүүдэд малчдын орлогыг хамгаалах хүрээнд хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлэх чиглэлийн зорилтуудыг бас нөгөө дундаж давхаргыг нэмэгдүүлэх чиглэл дээр энэ үр дүнгээ өгнө гэж.

Дээрээс нь сая төсвийн хүрээн дээр хүртэл бид нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн, тэнцвэржүүлсэн орлого хоёрынхоо харьцааг 37-гоос 30 руу бууруулсан. Энэ бол төр оролцоогоо багасгаж байна л гэсэн үг. Үүнийг амилуулахын тулд Эдийн засгийн эрх чөлөөний хууль, Хөрөнгө оруулалтын хууль, Зөвшөөрөл, мэдэгдлийн хуулийг маргааш Засгаар оруулах гэж байна.

Тэгээд Татварын багц хууль. Ингэж байж, үүнийг бүхэлдээ бодлогын чиглэл явна. Аль яам хуулийг нь оруулах юм, аль яам ямар арга хэмжээ авах юм, аль яам төсөл, арга хэмжээнүүдээ хэрэгжүүлэх юм бэ гээд ангилна. Ажлын хэсгээс... /минут дуусав/

Ч.Лодойсамбуу: П.Батчимэг гишүүн тодруулъя.

П.Батчимэг: Н.Учрал сайд аа, ер нь миний гол сонирхсон асуулт 2026-2030 онд хөгжүүлэх үндсэн чиглэл үе үеийн Засгийн газрын боловсруулж ирсэн үндсэн зарчмаас ялгаатай ер нь ахиц дэвшил авчрах хөгжүүлэх яг тийм бодит баримт бичиг болж чадсан уу гэдэг дээр л асуулт асуусан.

Бас хүний нөөцийн асуудал. Өнөөдөр хөдөө аж ахуйн салбар, нэн ялангуяа хүний нөөцийн асуудал, мэргэжилтэй боловсон хүчин, чадвартай. ажиллах хүчнийг бэлтгэх асуудал Монгол Улсын хэмжээнд үнэхээр уналттай байгаа.

Ажлын байр байгаа боловч өнөөдөр ажлын байранд тогтвортой ажиллах тийм баталгаа байхгүй болсон. Энэ тал дээр яг өнөөдөр хүний нөөц дээрээ анхаарахгүй бол өнөөдөр болохоо больсон байна шүү дээ. Та энэ дээр нэг хариулт өгөөч.

Ч.Лодойсамбуу: Н.Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Яах вэ, энэ удаагийн таван жилийн чиглэл чанарын арга буюу тэр QUANTITATIVE арга хэрэглэхээс илүү тоон аргад суурилсан, тогтвортой

хөгжлийн зорилтуудтайгаа 72 хувийг нь уялдуулаад, олон улсад хүлээсэн үүргээ биелүүлэхэд манай шалгуур үзүүлэлтүүд хэрхэн нөлөөлөх вэ гэдгийг уялдуулсан, бодлогын хүрэх үр дүнг арга хэмжээнээс ялгаад үр дүн бүрийг хэмжих шалгуур үзүүлэлттэй болгосон.

Ингээд үндэсний 10 том үр дүнгээ тавиад түүнд –

- нөлөөлөх салбарын 35,
- төсвийн ерөнхийлөн захирагчийн 85,
- хөтөлбөрийн 200 үр дүн гээд
- ерөөсөө л 330 үр дүнг тавьснаараа ялгаатай.

Мөн дээрээс нь олон нийтийн оролцоог хангаад 14 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулаад салбар болгоны үр дүнгүүдийг Шинжлэх ухааны академийн 6 Бага чуулганаар хэлэлцүүлээд, Их чуулганаар дэмжүүлээд, шинжлэх ухаанд суурилсан таван жилийн чиглэл боловсруулсан.

Хариуцлага тооцох механизм бас бий болгосон.

Тэгээд Ж.Энхбаяр сайд нэмж хариулъя.

Ж.Энхбаяр: Улс орны хөгжлийн асуудлыг харахад бид ер нь бүхий л салбарыг хамарсан хүний нөөцийн асуудал, ажиллах хүчний гүн гүнзгий бид дутагдалд орсон байгаа.

Өнөөдөр ажиллах хүч бэлдэж байгаа боловсролын тогтолцоо, системээ бид цоо шинээр эргэж харж шинээр бодлого гаргахгүй бол одоо бэлдэж байгаа боловсон хүчин, хөгжлийн ирээдүйд бид бодож байгаа, зорьж байгаа хөгжлийн бодлогод шаардлага хангахгүй байдал байгаа. Үүнийг бид бодитоор хүлээн зөвшөөрч ялангуяа хүний нөөц бэлтгэх, боловсролын салбарт эрс шинэчлэл, өөрчлөлтийг хийхгүй бол бид хөгжлийн асуудал дээр олон улс орнуудаас хоцрогдоно гэдэг болгоомжлол буюу эрсдэл.

Тэгэхээр энэ чиглэлээр ганцхан хөдөө аж ахуй гэлтгүй, одоо жишээлбэл хөдөө аж ахуйн салбарт инновац, технологи маш хүчтэй нэвтэрч байна. Орчин үеийн техник, технологиуд... /минут дуусав/

Ч.Лодойсамбуу: Ганбатын Очирбат гишүүн асуултаа асууя.

Г.Очирбат: Өдрийн мэнд хүргэе.

Зарчмын гурван хэсэг асуулт асуух гэж байна.

▸ **Нэгдүгээрт,** тайлантай холбоотой. 2021-2025 оны хөгжлийн үндсэн чиглэл, хэрэгжилт, үнэлгээний тайланг Их Хурлын гишүүдэд ирүүлсэн

байгаа.

Энэ тайлан дээр ерөөсөө Засгийн газрын хэрэгжилтийн үнэлгээний тайлангаас үзэхэд 95 шалгуур үзүүлэлтээс 34 хувь нь хүрсэн. Хүрсэн түвшин нь 85 хувиас доош буюу үр дүн гарсан. 53 хувь нь 85 хувь буюу үр дүн гараагүй, 8 шалгуур үзүүлэлтээр ажил хийгдээгүй гээд.

Ингээд үндсэндээ 50 хувь. Энэ 5 жилд чинь ямар ч ажил хийгдээгүй юм шиг харагдаад байгаа юм.

➤ **Хоёрдугаарт**, 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр дээр нийт 336 төсөл, хөтөлбөр, хэмжээ тусгагдсанаас 176 нь буюу 52 хувь нь хэрэгжсэн. 59 арга хэмжээ буюу 18 хувь нь хэрэгжиж байгаа. 101 нь хэрэгжиж эхлээгүй гэж байгаа юм. 30 хувь нь.

Тэгэхээр ер нь бид 2021-2025 онд улсын төсвөөр дамжуулаад 120 орчим их наяд төгрөгийг үрсэн.

Тэгээд үүний чинь үр дүн хаана байгаа юм?

Тэгэхээр бид эхлээд ер нь тайлангаа яримаар байгаа юм. Зарчмын асуудлаа нэг бүрчлэн ярья.

Тайлантай холбоотойгоор Монгол Улсын 2020 оны 5 сарын 13-ны өдөр “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын батлах тухай одоогийн Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар Их Хурлын дарга байхдаа тогтоол баталсан.

Энэ тогтоол 3 хавсралттай. 3 хавсралтын хамгийн гол хавсралт буюу 3 дугаар хавсралт байгаа.

Хэмжих нэгжгүй, үзүүлэлтгүй гээд байгаа. Энэ дээр бүр тодорхой бичсэн. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг үзүүлэлт хүрэх түвшин гээд.

- Энд хэмжих нэгж нь юу юм?
- 2025 онд хэдэн хувьд хүрсэн байх ёстой юм?
- 2030 онд ямар байх ёстой юм?
- 2050 онд ямар байх ёстой юм? –

гээд ингээд тавьсан. Үүнтэй холбогдуулаад би дахиад энэ сайхан ном ирсэн. 2021-2030 он гэж байгаа юм. Хамгийн эхний ажил. Энэ дээр ингэж байгаа юм.

Монгол Улсын хүний хөгжлийн индексийг 0.81-ээс дээш түвшинд хүргэнэ гэж байгаа юм. Тэгээд 2020 онд батлагдсан тогтоол дээр Хүний хөгжлийн үзүүлэлт индексээр хэмжинэ.

- 2020 онд 0.74,
- 2025 он 0.77,
- 2030 онд 0.85 хүргэнэ гэж байгаа юм.

Тэгэхээр Монгол Улсын Ерөнхий сайд маань ухрах гээд байгаа юм уу, урагшлах гээд байгаа юм уу, хөгжих гээд байгаа юм уу? Хөшиж зогсох гээд байгаа юм уу? Хөшөө зогссон энэ дээр. 0.81-ээс дээшээ байлгана гэж байгаа юм.

2030 он гэхэд 0.85 хүргэ гээд тогтоолоо өөрөө Их Хурлын дарга байхдаа баталсан байгаа шүү дээ.

Дараагийнх нь, ингэж байгаа юм. Дараагийнх нь. 1 минутаа нэмье. Тэгэх үү? Нэлээн олон асуултууд байгаа учраа.

Ч.Лодойсамбуу: Г.Очирбат гишүүний микрофоныг 1 минутаар нэмье.

Г.Очирбат: Дараагийнх нь гэж байгаа юм.

Дундаж давхаргын эзлэх хувийг одоогийн 40 орчмоос 60 хувьд хүргэх буюу 20 хувиар нэмэгдүүлнэ гэж байгаа юм. Тэгээд дахиад энэ хавсралтын 3. Амьдралын чанар ба дундаж давхарга гэж байгаа.

- Дундаж ба түүнээс дээш давхаргын иргэдийн эзлэх хувийг 71.6 байсан байгаа. Үүнийг –
- 2025 онд 80,
- 2030 онд 85 хувьд хүргэнэ гэж байгаа байхгүй юу.

Тэгээд 2021-2025 онд юу хийснийгээ сайхан үнэлмээр байгаа юм. Нэгд.

Хоёрт, 2026-2030 онд хийх гээд байгаа ажлууд нь бүгд хойшоо ухарсан байдалтайгаар ийм сайхан ном орж ирж байна.

Тэгэхээр тайлангаа Байнгын хороодоор бүгдээр нь хэлэлцээд өнгөрсөн таван жилийн хугацаанд Монгол Ардын намынхан эрх барьж байхдаа улс эх орны 120 их наяд төгрөг... /минут дуусав/

Ч.Лодойсамбуу: Н.Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Г.Очирбат гишүүн их зөв асуудал хөндөж байгаа шүү.

Тэгээд ер нь үнэнээ ярина бүгдээрээ. Хэдүүлээ нэг худлаа мөрөөдлийн жагсаалт олон жил ярьж, манай Их Хурал 566 бодлогын баримт бичиг баталж, эмх замбараагүй төлөвлөлтийн хор гайгаар өнөөдрийг хүрээд байгаа шүү дээ.

Тэр Их Хурлын тогтоол дээр 0.85 хүрэхгүй ээ.

Бодитоор нь тооцоолоод үзэхэд бусад хүчин зүйлийн нөлөөгөөр 0.81 рүү л очно. Яах вэ, 0.85 хүрнэ гээд бичвэл бичнэ л дээ. Монголд бол мөрөөдлийн жагсаалт зөндөө байгаа.

Энэ таван жилийн чиглэл мөрөөдөл биш байгаасай л гэж бодсон.

Тийм учраас хаана байна, хаашаа явах вэ, яаж явах вэ, хэзээ очсон байх вэ гэдгийг тодорхойлох ёстой шүү дээ.

Тийм учраас хаана байгаагаа бодит байдлаар нь тодорхойлъя гэдэг зорилгоор энэ удаагийн таван жилийн чиглэлийг хэмжиж болохуйцаар хийсэн.

Тийм учраас өмнө нь гарсан байгаа тэр тогтоол шийдвэр, бодлогын чиглэлүүд, тэгээд эргээд үнэлэхэд дандаа хангалтгүй байгаа. Төрийн байгуулалтын байнгын хороон дээр үнэлгээ хийх гээд орж ирэхэд тэр дандаа л хангалтгүй үнэлэгдээд байгаа шүү дээ. Энэ удаагийн чиглэл процесс үнэлээгүй байхгүй юу.

Бид өнгөрсөн хугацаанд дандаа процесс үнэлж явсан юм билээ. Жишээ нь, эдийн засгийн эрх чөлөөний индекс дэлхийн улсуудын эхний 60-д орно гэдэг энэ таван жилийн бодлогын чиглэлийн 2030 оны зорилт. Индикатор.

Гэтэл эдийн засгийн эрх чөлөөний индексийг тэр эхний 60-д оруулах нь үр дүн юм уу, эсвэл эдийн засгийн эрх чөлөөг ахиулахын тулд Монголын эдийн засгийн форум 2 удаа арга хэмжээг сайхан хийлээ, Даосын чуулганд оролцлоо гэдэг нь ажил юм уу гээд.

Тэгэхээр үр дүнг үнэлээд чанарын аргаар үнэлэх гэхээр хэдэн зургууд хэвлэж тавиад бид ажил хийсэн. Бид ингэсэн, сайхан болж байгаа гэхээр үнэлэхгүй байж болдоггүй. 60, 70 хувь тавьсан болоод. Тэгээд орж ирээд энд бие биеэ аргадсан болоод өнгөрсөөр байгаад өнөөдөр хүрсэн байхгүй юу. Мянган форумд оролцсон уу, мянган арга хэмжээ хийнэ үү тэр процесс хийнэ үү тэр хамаагүй. Энэ улсыг эдийн засгийн эрх чөлөөний индексээр эхний 60-д оруулаагүй бол тэр Эдийн засгийн яам, тэр Сангийн яамны буруу л гэж үнэлдэг байвал эргээд хэн хэнийхээ өмнө хариуцлагатай байя л гэж бодож байгаа.

Тийм учраас энэ таван жилийн бодлогын чиглэл мөрөөдлийн жагсаалт бол биш ээ.

Тийм учраас таны шүүмжилж байгаатай би санал нэг байгаа.

Тэгэхээр бүгдээрээ бодит үнэнээ ярих ёстой. Жил болгон төсөв ч гэсэн адилхан орлогоо хэт өөдрөгөөр төсөөлөөд л замынхаа дундаас fail-дээд л явж байгаа шүү дээ. Балраад л явж байгаа шүү дээ. Тийм.

Тэгэхээр ер нь жоохон үнэнээ ярина. Бүгдээрээ. Тийм. Ер нь нэг их тийм дэлхийн том том юм яриад хэрэггүй шүү дээ. Ер нь хөгжил гэдэг бол тасралтгүй хөдөлгөөн. Ахиц л гарах ёстой. Ахиц, прогресс гарах ёстой.

Түүнээс биш зүгээр л гэнэт нэг сайн сайхан болохгүй.

Тэгэхээр энэ таван жилийн чиглэлийг хараад үзэх юм бол нэг их тийм агаарын тоонууд байхгүй дээ. Ер нь жоохон ахиц үзүүлье, арай жоохон урагшилья гэсэн.

Тэгээд таван жилийн чиглэл ч бай, үйл ажиллагааны хөтөлбөр ч бай, жилийн төлөвлөгөө ч бай ороод ирэхээр нөгөө тойргуудын асуудлаа суулгадаг, жалга довны асуудлууд яригддаг. Тэгсээр байгаад эргээд харахад бүр танихын аргагүй юм болоод гараад ирэхээр нөгөөдхийг нь биелүүлэх гэж явсаар байтал дараа жил болдог.

Тэгээд тайлан ороод ирээд хэлэлцүүлэх гэхээр хангалтгүй, хангалтгүй гээд бие биеэ илээд таалаад болж байгаа ч юм шиг, нэг харахаар хөгжсөн ч юм шиг, хөгжөөгүй ч юм шиг явсаар байгаад тэгээд хэн нь буруутай нь ч мэдэгдэхгүй ийм л юм руу явчхаад байна л даа.

Тийм учраас бүгдээрээ энэ таван жилийн чиглэл дээр яг тодорхой асуудлаа суулгая. 200 хөтөлбөрийн үр дүн. 30 тэрбумаас дээш төслүүд энд сууна. Бусад нь суухгүй. Суухдаа тэргүүн ээлжид аль нь вэ. Эрэмбэлье.

Тийм учраас сая шинэ Засгийн газар байгуулагдаад 14 мега төслийг ч тэр, яам болгон дээр байсан төслүүдийг ч тэр бүгдийг нь эрэмбэлсэн. Тэргүүн ээлжид аль аль нь вэ гэдгээ хэрэгжүүлсэн.

Ч.Лодойсамбуу: Г.Очирбат гишүүн тодруулъя.

Асуултууд зөндөө их байна. Би яах вэ, Н.Учрал сайдтай Ардчилсан намын бүлэг дээр нэлээн санал солилцсон байгаа.

Дээрээс нь Монгол Улсын хөгжлийн “Алсын хараа-2050” батлагдаад Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиараа 6.5 дээр ийм 8 үзүүлэлтүүдийг батлуулах ёстой. Тэгээд энэ орж ирээгүй. Энэ бол одоо ингээд 10 жилийн дунд хугацааных, тэгээд 5 жил, 4 жил, 1 жил гэж орж ирж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ 10 жилийнх нь байхгүй байж байгаад 5 жилийнх нь шууд ороод ирж байгаа юм.

Тэгээд үүнийгээ манай яамныхан юу гэж харж байгаа? Хэзээ батлуулах юм? Н.Учрал сайд бодлогын бичиг баримт нь гарсан байгаа. Явуулна гэсэн. Одоогийн байдлаар ирээгүй байгаа.

Тэгээд ер нь ярих гээд байгаа гол юм бол ерөөсөө өмнө нь алдсан алдаануудаа засаж залруулж явахгүй бол болохгүй байна. Зүгээр сайхан чихэн дээр цэцэг ургуулаад л. Одоо чуулган дээр үг хэлэхээс хүртэл залхаж байгаа шүү дээ.

Тэгээд хариулдаг хэдэн хариулттай. Асуусан болдог. Хариулсан болдог. Ийм байдлаар улс эх орон хөгжихгүй шүү л гэж хэлэх гээд байгаа юм.

Ч.Лодойсамбуу: Н.Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Тийм. Энэ таван жилийн бодлогын чиглэл дээр тэр 8 зорилт, хөтөлбөрийг дотор нь бүлэг болгоод оруулаад ирсэн. Энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын хуулийн нэмэлт, өөрчлөлтийг боловсруулах ажлын хэсэг ажиллаж байгаа. Их Хурлын гишүүдээс бүрдсэн. Тэр ажлын хэсгийнхэнтэй санал солилцлоо.

Тэгээд ер нь 8 зорилт, хөтөлбөрөө дотор нь оруулаад ирэхгүй бол 8 удаа ийм бичиг баримт баталбал хэдүүлээ ер нь бичиг баримт хэлэлцсээр байгаад дуусах гээд байгаа байхгүй юу.

Тийм учраас ингээд ер нь боловсруулаад дууссан байгаа хуультай юм чинь бид ажлаа хийж байна. Гэхдээ ажлын хэсгийнхэн юу гэсэн бэ гэхээр энэ дотроо ингээд 8 зорилт, хөтөлбөрөө бүлэг болгож оруулж нэг бодлогын баримт бич болгохгүй бол дахиад 8 ийм бичиг баримт орж ирээд явах нь зохимжтой юу, үгүй юу гээд бид өргөн барихаас эхлээд таван жилийн чиглэлээ явуулъя гээд зогссон.

Түүнээс биш 8 зорилт, хөтөлбөр бол боловсруулсан байгаа.

Ч.Лодойсамбуу: Жаргалсайханы Золжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Золжаргал: Нүүрс, химийн үйлдвэрлэлийн талаар орхигдуулсан уу эсвэл одоогоор тодорхой биш байна, бэлэн биш байна гэсэн үндэслэлээр орхисон уу гэдгийг л тодруулж асуумаар байгаа. Одоо нүүрс чинь зөвхөн зарж мөнгө олдог. Тэгээд бас нэг баахан хэл ам болдгоос гадна материалын түүхий эд болсон.

Тэгээд энэ шинэ технологи биш бүр хуучирсан. Би сая энд асуулт асуух гээд хараад сууж байна лээ л дээ. Олон улсын эрчим хүчний агентлагийн тайланд Дэлхийн 9 тэрбум тонн нүүрсний талыг нь 4.5-ыг нь Хятад хэрэглэдэг. 4.5-аасаа 1 тэрбумыг нь түлшний бус зориулалтаар хэрэглэдэг. Коксыг оруулахгүйгээр. Тэгээд тэр нь цементийн үйлдвэрт нэг хэсэг. Тал нь хими. Нөгөө шатахуун. Бид чинь шатахуун, нефтийн үйлдвэр барих гэсэн чинь эх үүсвэр асуудалтай болоод байгаа шүү дээ.

Тэгээд ч бүрэн хангахгүй. Нүүрснээс бензин шатахуун үйлдвэрлэдэг, хуванцар материал үйлдвэрлэдэг, будаг цавуу үйлдвэрлэдэг салбар бие даагаад

хөгжсөн. 1 тэрбум тонн нүүрсний хэрэглээ гэдэг бол Монголоос 15 дахин том гэсэн үг шүү дээ. Нийт үйлдвэрлэлээс.

Тэгэхээр энэ бол хуучин зүйл. Энэ хөрөнгө оруулалтын хөтөлбөр дээр юу байна л даа. Хоёр, гурван юм. Алтанширээт гэж байна. Тавантолгойн кокс эрчим хүч гэж байна. Эд нар яг энэ нөгөө нүүрс, хими биш кокс талын юмнууд. Багануур дээр нүүрс, пиролиз² гэж байна. Тэр нь шахмал түлшний үйлдвэр.

Тэгэхээр ийм гурван зүйл байна. Нүүрс, хими нь ороогүй юм байна.

Уг нь Дэлхийн банкнаас Монгол Улсын Засгийн газар зээл аваад хуучны Уул уурхайн яам Багануур дээр том нүүрс, химийн нүүрснээс шатахуун үйлдвэрлэх, зуны цагт болохоор байгалийн хий үйлдвэрлэх эсрэгээрээ төсөл, ТЭЗҮ хийгээд баталсан байгаа.

Түрүүчийн хамтарсан Засгийн газрын 2024-2028 хөтөлбөрт нүүрс, химийн туршилтын үйлдвэрийг ажиллуулж сурах гээд орсон байгаа. Бас ТЭЗҮ-тэй.

Тэгэхээр энэ ажлуудыг Та бүхэн маань эндээ орхигдуулав уу, эсвэл оруулах цаг нь болоогүй гэж үзсэн юм уу? Энэ тал дээр ер нь ажлын хэсэгтэй уулзаж санал тавьж санал солилцмоор байна.

Ч.Лодойсамбуу: Н.Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Ер нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан 14 мега төслийг 4 бүлэг, 15 зүйл, аргачлалаар үнэлсэн. Яам болгон дээр байгаа төслүүдийг үнэлсэн.

Тэгээд ер нь жоохон цэгцлэх гээд л оролдоод байгаа. Зураг төсөв, ТЭЗҮ-нүүд ч гэсэн яам болгон дээр байдаг юм байна. Үүнийг татаж авч байна. Энэ дээр нэг магадлал хийлгээд бэлэн зургуудаа ядаж нэг цэгцэлье гээд зориод л байна.

Зурагтай, төсөвтэй, санхүүжилт нь тодорхой бус гээд ангилаад. Тэгээд ямар ч байсан яам болгон дээр байгаа төслүүдээ татаж аваад эрэмбэлж байна. Дуусгасан. 14 төслөө дуусгасан.

14 мега төсөл дээр тэр нүүрс, химийн цогцолбор төслүүд дотор бий. Энэ удаагийн таван жилийн бодлогын чиглэлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр дотор нүүрс, химийн цогцолбор гээд байгаа. 2025-2030. Санхүүжилтийн эх үүсвэр нь шууд хөрөнгө оруулалтаар гээд. Төсвөөс биш. “Эрдэнэс Монгол” компани хэрэгжүүлнэ. ТЭЗҮ нь хийгдэж байгаа. Санхүүжих дүн гээд ер нь тусгасан. 4 дүгээр хавсралт дээр.

Тэгэхдээ санхүүжилт шийдвэрлэх шаардлагатай төслүүдийн жагсаалтад хамарч байгаа гэсэн үг.

² Дулаанаар задлах үйл явц.

Тэгэхээр бид үүнийг тэргүүн ээлжид хэрэгжүүлнэ. Ач холбогдол өндөртэй мөртөө SOCIAL IMPACT³ нь өндөртэй мөртөө зураг төсөв, ТЭЗҮ бас бүрэн бэлэн биш, санхүүжилт тодорхойгүй.

Тэгэхээр эрэмбээрээ хойшоо ороод байгаа. Ач холбогдол өндөртэй төслөөр өндөрт эрэмбэлэгдсэн гэдгийг хэлье.

Тэгээд энэ нүүрс, химийн цогцолборын төсөл ямар түвшинд хэрэгжиж байгаа вэ гэдэг талаар ажлын хэсгээс нэмж хариулъя.

Тэгээд С.Наранцогт захирал. Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

С.Наранцогт: Ж.Золжаргал гишүүний асуултад хариулъя.

Багануурын нүүрс, химийн цогцолбор, Багануурт үйлдвэр, технологийн паркийн төлөвлөлт, хөгжлийн төлөвлөгөө хийгдээд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаман дээр батлагдсан.

Энэ хоёр шаттай явах юм. Эхний шат нь нүүрс, пиролизийн гэж саяын таны хэлээд байгаа нүүрсээ цэвэршүүлэхэд. Та үүнийг сайн мэдэж байгаа хэсэг. Тэгээд энэ нэрээр нь орсон юм шиг байна. Зүгээр тэгж уншигдаад байх шиг байна.

Яг үнэндээ таны хэлж байгаа нүүрс, химийн цогцолбор баригдана. Үүгээр эхний ээлжид нүүрс, пиролизийн үйлдвэр буюу нүүрсээ цэвэрлэх. Энэ 2 сая тонн нүүрс бид боловсруулах ТЭЗҮ хийгдээд дуусаад, яг Эрдэс баялгийн зөвлөл дээр хэлэлцэгдэж байна.

Үүний дараа бид таны ярьж байгаа... /минут дуусав/

Ч.Лодойсамбуу: 3 дугаар микрофоныг өгье. Гүйцэд хариулъя.

С.Наранцогт: Дараагийн шатанд бид нүүрсийг хийжүүлэх, байгалийн хий, нефть, шингэрүүлсэн хий, аммони сульфат зэрэг бүтээгдэхүүн нүүрснээс боловсруулах ийм төлөвлөгөө хөгжлийн төлөвлөгөөнд орсон байгаа.

Энэ түвшинд “Эрдэнэс Монгол” төрийн өмчийн компани хийнэ. Энэ дээр цахилгааны эх үүсвэр бас давхар баригдана. Үүнээс цааш дараа шатын боловсруулалтуудыг хувийн хэвшилд үйлдвэр, технологийн паркийн загвараар хувийн хэвшил энэ боловсруулсан түвшний бүтээгдэхүүнүүдээ ашиглаад дараа дараагийн бүтээгдэхүүнүүдийг, бусад төрлийн бүтээгдэхүүнүүдийг хийх ийм боломжтой болох юм.

Ч.Лодойсамбуу: Ж.Золжаргал гишүүн тодруулъя.

³ Нийгэмд үзүүлж буй нөлөөлөл, үр дагавар. Эерэг эсвэл сөрөг нөлөө.

Ж.Золжаргал: Ерөнхийдөө ойлголоо. Ер нь бас бэлэн биш байгаа. Тэр хэмжээний юм гэсэн утгаар ач холбогдлын хувьд хойд талд орсон юм байна.

Тодруулаад хоёр зүйл хэлье.

Нэгдүгээрт нь, Багануурт барих нүүрс, химийн эхний шат биш ээ. Энэ бол хагас коксон шахмал түлшний үйлдвэрийн түүхий эдийг гаргаж авна. Зөв биз. Тийм байна. Тэгэхээр тусад нь ойлгомоор байна.

Нөгөө шатахуун, бензин, химийн нийлэг, байгалийн хий гэдэг тусдаа зүйл. Тэрийг “Эрдэнэс Монгол” байгуулагдахаас өмнө ч бай, зөндөө улсын зардлаар судалгаанууд хийгдээд, ТЭЗҮ хийгээд, Дэлхийн банкны юугаар гараад олон улсын экспертүүд гараад баталсан байдаг юм.

Тийм болохоор “Эрдэнэс Монгол” оролцохоос өмнөх материалуудыг бэлэн биш гэж үзэж болохгүй шүү. Үүнийгээ эргэж хараарай гэж хэлмээр байна. Бэлтгэгдсэн, үйлдвэрлэлд нэвтэрсэн ийм зүйл.

Ч.Лодойсамбуу: Мэндбаярын Мандхай гишүүн асуултаа асууя.

М.Мандхай: Таван жилийн үндсэн чиглэлийг бид ярьж байгаад баяртай байна.

Тэгээд хөдөө аж ахуйн салбар луу илүү чиглүүлээд асууя гэж бодож байгаа. Сүүлийн 5 жилийг харах юм бол ер нь хөдөө аж ахуй, газар тариаланд 2 их наяд гаруй төгрөгийн төсвийг бид зарцуулжээ. Гэсэн хэдий ч өнөөдөр нэг хүнд ногдож байгаа гурил, гурилан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн гээд гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүн дотоодын үйлдвэрлэл өсөөгүй байгаа. Статистикаар харж болно.

Тэгэхээр юу хэлж байна гэхээр бид хүнсний үнийн инфляцыг тэргүүлсээр байгаад байдаг. Хэрэглээний үнийн индекс өөрөө бараг 61 хувьтай ч билүү нэмэгдсэн. Дээрээс нь хүнсний бүтээгдэхүүний дэд индекс өөрөө 86 пунктээр бас нэмэгдсэн байгаа.

Үүний шалтгаан нь өөрөө юу хэлж байна гэхээр бид дотоодын үйлдвэрлэлийг ерөөсөө нэмэгдүүлж чадаагүй буюу одоо энэ хүнсний нийлүүлэлтийн хомсдолд орсон, бүтээмжийн доройтолтой байгаа нөхцөл байдал байгаа юм.

Тэгэхээр энэ салбаруудыг яг ямар ч байсан дэмжих. Дэмжих гэж байгаа бол гол нь хөнгөлөлттэй зээл өгөхөөс гадна илүү хөрсөн дээр буусан бүтээмжийг нэмэгдүүлэх бодлого хэрэгтэй байна. Яг энэ рүү чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай байгаа юм. Ялангуяа хөдөө аж ахуйн салбарын гол шийдэл нь хөрөнгө мөнгө, их хэмжээний тоног төхөөрөмж зарцуулаад байгаа нь өөрөө нөгөө талдаа бүтээмж нэмэгдэхгүй байгаа учраас дотооддоо хүнсийг үйлдвэрлэх, хүнсний хангамжийг нэмэгдүүлэх энэ ажил явахгүй байгаа юм.

Тэгэхээр энэ дээр бүтцийн шинэчлэл, шинжлэх ухаанд суурилсан технологийн хөрөнгө оруулалт. Дээрээс нь өртгийн сүлжээг хөгжүүлэхгүй бол явахгүй байгаа юм.

Тэгээд энэ 5 чиглэлийг харлаа. Энэ дээр 4.3.1. 4.3 дээр “хүнсний аюулгүй байдлыг сайжруулна” гэсэн байгаа. Хүнсний аюулгүй байдлыг сайжруулна гэсэн хэсгийн 4.3.1.1-д “олон улсын стандарт, шаардлага хангасан хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ” гэж тусгасныг нь илүү бодлогын зорилго буюу энэ “эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангана” гэдэг дээр шилжүүлэх саналтай байгаа юм.

Бид хөдөө аж ахуйн салбарыг эдийн засгийн үр өгөөжтэй салбар болгож хөгжүүлэхгүй бол бид зөвхөн хүнсний аюулгүй байдлыг сайжруулна гэдэг бүтэц дотор ороод л ирэхээр чинь энэ хүнсний аюулгүй байдал нь ч хангагддаггүй, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл сайжирдаггүй нэг ийм доголдолтой яваад байгаа юм.

Тийм учраас хөдөө аж ахуйн салбарыг бид хөгжүүлэе гэж бодож байгаа бол, хүнсний хангамжийг нэмэгдүүлэе гэж бодож байгаа бол энэ... /минут дуусав/

Ч.Лодойсамбуу: М.Мандхай гишүүнд нэмэлт 1 минут өгье.

М.Мандхай: Дараа нь хүнсний үйлдвэр өөрөө аж үйлдвэрийн салбарын нэг хэсэг байгаа. Тэгээд экспортыг нэмэгдүүлэх, импортыг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэж байгаа.

Гэтэл энэ салбарыг хөгжүүлэх, тус салбараас нь эдийн засгийн үр өгөөжийг бий болгох асуудлыг зөвхөн хүнсний аюулгүй байдлыг сайжруулах хүрээнд харж үндсэн чиглэлдээ томьёолох нь буруу гэж харж байгаа юм.

Малын гаралтай түүхий эдийг боловсруулах асуудал 5.1.2.1-д дурдсан байгаа. Үүнийг зөвхөн хөнгөн үйлдвэрт хамааралтай байж болохгүй юм. Энэ дээр нь анхаараач ээ. Одоо хамгийн наад зах нь бид махныхаа экспортыг тэгвэл бодохгүй юм уу гэдэг асуудал байгаа.

Тэгэхээр энэ нь өөрөө энэ чиглэлийгээ тооцохдоо. Одоо надад олон асуулт байгаа учраас би эхлээд хариултаа аваад үргэлжлүүлээд дахиад асууя гэж бодож байна.

Ч.Лодойсамбуу: Шинжлэх ухааны академийн академич Агипарын Бакей хариулна. 5 номерын микрофоныг өгье.

А.Бакей: Баярлалаа. М.Мандхай гишүүний асуултад хариулъя.

Яах вэ, энэ эхэлж хэлэхэд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль батлагдсанаас хойш, 2014 оноос хойш энэ үндсэн чиглэл бол хоёр дахь үндсэн чиглэл байгаа юм л даа.

Түрүүн гишүүд ярьж байна. Тэр бол үнэн. Өмнөх үндсэн чиглэлийг дүгнэж болохгүй, хэмжиж болохгүй баахан мөрөөдлийн жагсаалтыг үнэлэх гэхээр хэцүү байсан.

Энэ үндсэн чиглэлийн гол онцлог нь үр дүнд суурилсан, судалгаанд суурилсан, индекст суурилсан хэмжиж болох үндсэн чиглэл гэдгийг онцолж хэлэх нь зүйтэй.

Яах вэ, судлаач хүний хувьд бид үндсэн чиглэлийн боловсруулах шатад хөдөө аж ахуйн хэсэгт оролцсон.

Тийм учраас энэ дээрээ жишээлбэл хөдөө аж ахуйн өнөөдөр хамгийн тулгамдсан асуудал бол бэлчээрийн доройтол байна. Бэлчээрийн ачаалал маш их байна. Энэ дээр жишээлбэл бэлчээрийн 100 га талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо өнөөдөр зудтай жилийн тоогоор арай буурсан.

Ер нь бэлчээрийн 100 га талбайд 114 толгой мал ногддог байхгүй юу. Хонин толгойгоор. Үүнийг 2030 онд 96, 95-д хүргүүлэе гэж байгаа юм. Энэ бол индекс буюу хэмжиж болох үзүүлэлт.

Тэгвэл үүнийг хэрэгжүүлэх арга зам нь юу вэ гэхээр өсвөр насны малыг эрчимтэй аргаар тэжээж бойжуулж, бэлчээрийн ачааллыг бууруулах, махны экспортыг нэмэгдүүлэх, малын эдийн засгийн эргэлтийг сайжруулах гээд ийм аргуудаар энэ зүйл цаашаа явах ёстой.

Тийм учраас салбар болгоны сайд өөрийнхөө тэр тогтоосон хэмжиж болох үзүүлэлтэд хүрэхийн тулд тодорхой арга хэмжээг хэрэгжүүлээд явах ёстой. Яг түүнтэй адил таны асуугаад байгаа тэр хүнсний болоод хөнгөн үйлдвэрийн боловсруулах салбарын нийлүүлэлтийн сүлжээг цогц байдлаар авч үзэх ёстой болоод байгаа юм л даа. Өөрөөр зөвхөн хөдөө аж ахуйг дангаар, мал аж ахуйг дангаар хөгжүүлэе гэвэл боловсруулах үйлдвэр нь хөгжихгүй бол ялгаа байхгүй, эрэлт өсөхгүй, хөгжихгүй.

Тийм учраас боловсруулах салбарын боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, түүхий эдийн нийлүүлэлтийн сүлжээг оновчтой болгох замаар мал аж ахуйн үнэ цэнгүй болж байгаа түүхий эд, бүтээгдэхүүний эргэлтэд орж байж малчдын ч орлого нэмэгдэнэ, үндэсний боловсруулах үйлдвэр ч гэсэн хөгжинө.

Тийм учраас яг ийм уялдаатайгаар энэ асуудлыг аминдаа тусгасан гэж үзэж болно.

Мэдээж сайжруулах, боловсронгуй болгох асуудал байгаа байх. Үүнийг жил жилийн хөгжлийн төлөвлөгөө, улсын хөгжлийн төлөвлөгөө, улсын төсөвт тусгаад хэрэгжүүлээд явах ёстой байгаа юм.

Тийм учраас үндсэн чиглэл гэдэг бол хөгжлийн ерөнхийдөө удирдамж, чиглүүлэгч гэсэн үг. Үүнийг жил жилийнхээ төлөвлөгөө, төсвөөрөө илүү тодотгоод тэр үзүүлэлтдээ хүрэхийн төлөө явах ёстой л гэж бид ойлгож байгаа.

Ч.Лодойсамбуу: М.Мандхай гишүүн тодруулъя.

М.Мандхай: Яах вэ, зүгээр өмнөх төлөвлөлт хэрэгжүүлэлтийн гашуун туршлага байна л даа. Яг ингээд томъёоллоо буруу сагсанд хийрээр яг тэр хэмжээндээ төсвөө төлөвлөөд хэрэгжүүлэхдээ өөрөө цогцоороо хэрэгжиж чадахгүй яваад байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр ч гэсэн би жишээлбэл харж байна. Хөнгөн аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлнэ гээд 5.1.2 дээр. Энэ чинь өөрөө орон нутагт анхан шатанд таны хэлж байгаа малын гаралтай түүхий эдийг хүлээн авах, нөгөө чанараар нь үнэлэх тогтолцоог бүрдүүлэхгүйгээр бид хөнгөн үйлдвэрийн салбарыг чанартай үйлдвэрлэлийг сайжруулах боломж байхгүй. Гэтэл нөгөө л импортоор арьс болон бусад түүхий эдээ авдаг хэвээрээ байсаар байна.

Тэгэхээр иймд энэ асуудлыг 5.3 дахь хэсэгт нь заавал нэмж оруулмаар байгаа юм.

Мөн төвийн бүс. Одоо энэ стандартын шаардлага хангасан хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд нийлүүлэлтийг нэмэгдүүлнэ гэдэг дээр Эдийн засаг, хөгжлийн яаман дээр эрчим... /минут дуусав/

Ч.Лодойсамбуу: Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

А.Бакей: Мэдээж хэлэлцэх шатандаа Улсын Их Хурлын гишүүн болгон өөрийнхөө эрх мэдлийнхээ хүрээнд үүнийг сайжруулах, боловсронгуй болгох, нэмэх хасах зүйлүүдээ хийгээд явах учраас таны хэлж байгаа саналыг тусгах боломж байгаа байх гэж бодож байна.

Ч.Лодойсамбуу: Ж.Энхбаяр сайд нэмж хариулъя.

Ж.Энхбаяр: 5 жил хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт өсөлт алга гэж М.Мандхай гишүүн ер нь байн байн яриад байгаа юм.

Тэгээд ямар статистик аваад, хаанаас хараад байдаг юм. Тэрийгээ эргэж хэл, хянаарай.

Зөвхөн экспорт гэхэд 2020 онд чинь 400 хүрэхгүй сая долларын экспорттой хөдөө аж ахуйн салбар одоо тэрбум доллар хүрч байна шүү дээ. Зөвхөн энэ жилийн нэгдүгээр улирал гэхэд 36 хувийн өсөлт энэ салбар чинь дангаараа бий болгоод байна шүү дээ. 48 мянган ажлын байр бий болоод байна. Энэ чинь яах гэж бий болоод байгаа юм. Энэ чинь өсөлт яваад байгаа. Өдөр

болгон л үйлдвэр нээгдэж байна шүү дээ. Хүнсний үйлдвэрүүд нээгдэж байна, хөнгөн үйлдвэрүүд өргөтгөлөө хийж байна, шинээр байгуулагдаж байна.

Улсын Их Хурлын, Засгийн газрын тогтвортой хэрэгжүүлж байгаа

- “Хүнсний хувьсгал”,
- “Цагаан алт”,
- “Атрын-IV” аяны –

үр дүнд хөдөө аж ахуйн салбарт бодитой өсөлт гарч байгаа. Бодитой экспортлогч салбар болсон.

Энэ жил бид тэрбум долларын түвшинд экспортолдог салбартай болж байгаа. Эрдэнэтийн... /минут дуусав/

Ч.Лодойсамбуу: Их Хурлын гишүүд асуулт асууж, нэмж тодруулаад болсон. Эхлээд та асуулт асуухдаа нэмэлт 1 минутаа авсан. Сая нэмж тодруулсан. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Тогтоолын төсөлтэй холбоотой тогтоолын төслийг үзэл баримтлалын хувьд дэмжсэн, дэмжээгүй эсэх талаар үг хэлэх гишүүд нэрсээ өгье.

Жадамбын Энхбаяр гишүүнээр тасаллаа. Ирцийн дагуу. Мэндбаярын Мандхай гишүүн үг хэлнэ.

М.Мандхай: Тоо ерөөсөө худлаа хэлдэггүй. Тийм ээ. Үндэсний статистикийн газраас гаргаж байгаа тоог байнга харж байгаа.

2020 онд үндсэндээ хөдөө аж ахуй, газар тариалангийн аж үйлдвэр дээр 337.0 тэрбум төгрөг зарцуулж байсан бол 2024 онд энэ нэг дахин өссөн байгаа юм. 670.0.

Тэгэхээр оруулж байгаа хөрөнгө оруулалт, тоо хэмжээ мөнгөн дүнгээрээ нэмэгдээд байгаа юм.

Гэтэл одоо ингээд нэг хүнд ногдож байгаа гурил, гурилан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн гол нэр нэрийн төрлийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийн хэмжээг статистикийг нь хараарай. Өсөхгүй яваад байгаа юм.

Сүү, сүүн бүтээгдэхүүн 2020 онд 42.5 байхад, 2024 онд 44. Энэ тоо ерөөсөө өсөхгүй яваад байгаа байхгүй юу. Буудай гэхэд газар тариалан. Өнөөдөр 2020 онд 1 га центрээс авч байгаа центрийн хэмжээ 10.8 байхад 2024 онд 12.5, ингээд 2022 онд 11.2, 2023 онд 13.2 гээд энэ тоонууд чинь өөрөө энэ их хэмжээний, нэг дахин хөрөнгө оруулалт нэмэгдсэн байхад энэ хэмжээгээр л үйлдвэрлэлийн гарц чинь нэмэгдэх ёстой. Үүнийгээ дагаад хүнсний өөрийн чинь дотоодын үйлдвэрлэл нийлүүлэлт нэмэгдээд байхад хүнсний бүтээгдэхүүний үнэ чинь өөрөө буурах ёстой байхгүй юу.

Тэгэхээр бид жоохон эдийн засагч энэ тоогоо харахдаа арай өөр бүтээмжид суурилсан. Ажлын байр нэмэгдэж байгаа боловч тэгвэл энэ их хэмжээний зарцуулалт хийгдээд яагаад бүтээмж нэмэгдэж өнөөдөр хүнсээ бид импортоосоо доогуур үнэлгээгээр худалдаж авч чадахгүй байгаа юм. Нийлүүлэлт дутагдалтай байгаа юм. Энэ их хэмжээний “Атрын-IV” аян, “Хүнсний хувьсгал” гээд маш их хэмжээний хөрөнгө зарцуулаад байгаад байдаг. Бүтээмж нэмэгдэх хэмжээгээрээ тоо буурах ёстой.

Тэгэхээр бид жоохон эдийн засагч, энэ дээрээ жоохон анхааралтай хандуулж явахгүй бол дахиад ирэх 5 жилд бид маш их хэмжээний хөрөнгө, хөтөлбөр хэрэгжүүлээд дахиад энэ салбар хөгжихгүй байх, үнээ дийлэхгүй байх нөхцөл байдалд орох вий гэдгийг л би анхааруулж хэлмээр байгаа юм.

Ч.Лодойсамбуу: Дараагийн гишүүд үг хэлэхээс өмнө чуулганы нэгдсэн хуралдаан эхэлсэн байгаа. Одоо санал хураах гэж байх шиг байна. Гишүүдийг танхимд урьж байна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор дэмжсэн, дэмжээгүй гишүүд үг хэлж байгаа. Одоо 3 гишүүн үг хэлээд санал хураалт явна. Түүний араас Байнгын хорооны өнөөдөр хэлэлцэх хоёрдугаар асуудлаа хэлэлцэнэ. Түүний араас Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо хамтарсан хурал болно.

Тэгэхээр гишүүд танхимдаа орж ирээрэй. Мөнхчулууны Энхцэцэг гишүүн үгээ хэлье.

М.Энхцэцэг: Монгол Улсыг ирэх таван жилд хөгжүүлэх үндсэн чиглэлийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Дэмжиж байгаа.

Ялангуяа хөгжлийн чиглэлийн үндсэн зорилго, зорилтуудаа хэмжих хэмжигдэхүйц байдлаар боловсруулсан бол нэлээн сайн байна гэж үзэж байгаа. Гэхдээ мэдээж энэ дээр сайжруулах зүйлүүд нэлээн их байна.

Тийм учраас гишүүдийн асууж байгаа асуултыг, хэлж байгаа саналыг маш анхааралтай сонсож, энэ үндсэн чиглэлээ сайжруулах чиглэл рүү яавал үр дүнтэй ашиглах вэ гэдэг тал дээр ажиллах нь зүйтэй юм байна гэсэн саналыг хэлмээр байна.

Ялангуяа эрчим хүчний тал дээр би түрүүн хэлсэн. Цахилгаан эрчим хүчний зах зээлийг либералчлах, чөлөөтэй өрсөлдөөнтэй болгох ажлыг ирэх таван жилд яг хэдэн хувьтай хийх юм бэ гэдэг бодлогоо, шийдвэрээ, энэ бичиг баримтдаа тусгах ёстой.

Тэгэхгүйгээр цахилгаан эрчим хүчний тухай хуулийг бичнэ гэсэн ойлголт ерөөсөө байхгүй байгаа. Өөрөөр хэлбэл зах зээлийг либералчлах ажлыг хийх юм уу, хийхгүй юм уу гэдэг шийдвэрээ Засгийн газар, Эрчим хүчний яам гаргах хэрэгтэй байх.

Тэгээд тэр шийдвэр гарсны үндсэн дээр тэр шийдвэрийг, тэр бодлогыг хэрэгжүүлэх хууль нь бичигдэнэ. Тэгэхээр үүнийг түрүүн эсрэгээрээ хариулаад байх шиг байна лээ.

Тэгэхээр үүнийг тусгаад үндсэн чиглэлээ сайжруулах ажлаа хийх нь зүйтэй гэсэн саналыг оруулмаар байна.

Хоёрдугаар ажил болохоор тэр Хөгжлийн тухай хууль дээр салбарууд бодлого гаргахыг хориглосон. Тийм ч учраас салбар бодлого гаргахгүй гээд байгаа.

Тэгэхээр тэр асуудлыг цаашид цэгцлэх ажлыг Засгийн газар хийгээч ээ. Эсвэл тэр 2050 дээр зөвхөн жагсаалт байдаг. Саяынх дээр ч гэсэн би жагсаалт гэж хэлснээс болоод жаахан реакцлаад уурлаад байх шиг байна л даа.

Тэгэхдээ Та бүхэн зүгээр л хараарай. Ямар ч байсан ингээд нэг ийм дэлгэрэнгүй бодлогын бичиг баримт биш байгаа байхгүй юу. Стратеги биш байгаа байхгүй юу. Тэгэхээр эсвэл энэ 2050, энэ бичиг баримтаа нэлээн дэлгэрэнгүй сайн бодлогын бичиг баримт болгооч. Эсвэл тэр хууль дээрээ өөрчлөлт оруулаад салбарыг өөрсдийнхөө бодлогыг цаашаа яаж хөгжих гээд байгаа тэр стратегиа гаргах тэр боломжийг нь нээж өгөөч ээ. Энэ ажлыг Засгийн газар хийгээч гэдэг ийм саналыг хэлмээр байна.

Ялангуяа гишүүдийн хэлж байгаа санал, асуултад реакцалж уурлаж бухимдахаасаа илүүтэй энэ хүн чухам юу хэлээд байна гэдгийг анхааралтай сонсоод, энэ хүний хэлж байгаа юмыг, боловсруулсан бичиг баримтыг сайжруулах чиглэл рүү яавал үр дүнтэй ашиглаж болох вэ гэдэг рүү жоохон өөр нүдээр хараад ажиллаач ээ. Тэгэхгүй бол хүний асуултыг, хүний саналыг сонсохоосоо өмнө уурлаад бухимдаад байхаар тэр чиглэл рүү ажиллах боломжгүй болдог юм аа.

Тэгээд хамгийн гол чухал юм нь Цахилгаан эрчим хүчний тухай хуулийг бид боловсруулж байгаа. Гэхдээ Эрчим хүчний яамнаас, Засгийн газраас үнэхээр зах зээлээ либералчлах хэдэн хувиар либералчлах юм, энэ таван жилд 5 хувиар либералчилна, эсвэл 10 хувиар либералчилна гэдэг юмаа гаргахгүй л бол энэ хууль бичигдэхгүй ээ гэдгийг маш товч бөгөөд тодорхой хэлье.

Хоёрдугаарт, либералчлах гэхээр буруу ойлголт дандаа яриад байх юм. Нэг л их хувьчлах тухай яриад байх юм. Тэгэхээр энэ биш юм гэдгийг бас ойлголтоо зөв бол олгооч ээ. Бүх хүмүүс тэгж ярих юм. Либералчилна гэхээр л төрийн өмчийн компаниудыг, сүлжээг хувьчилна гэж яриад байх юм. Гэтэл бид зах зээлийг либералчлах, чөлөөтэй өрсөлдөөнтэй болгох тухай хуулийг яриад байгаа байхгүй юу.

Тэгэхээр үүнийгээ хүртэл хууль дээрээ бодлогын бичиг баримтаа тусгавал хууль явна. Түүнээс биш эсрэгээрээ хууль гарвал бид бодлогоо гаргая гэж ярьдаг чинь буруу шүү. Үүнийгээ засаарай гэж хэлмээр байна.

Ч.Лодойсамбуу: Одоо нэг гишүүн үг хэлсний дараа санал хураалт явна. Гишүүдийн туслахууд гишүүддээ хэлээд танхим руу нь явуулаарай. Мөн сайд нар бас гишүүддээ хэлж танхим руу нь явуулаарай. Шууд санал хураана.

Ганбатын Очирбат гишүүн үгээ хэлье.

Г.Очирбат: Монгол Улсад хүн биш хууль засаглана гээд байгаа.

Тэгээд хууль засаглавал хуулиа мөрдмөөр байгаа юм. Монгол Улсын Үндсэн хуулийн 25.1.7 дээр хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна гэж байгаа.

- Стратеги төлөвлөгөө гарсан.
- Дунд хугацааны төлөвлөгөө гараад явах ёстой.

Үүнийг 2020 оны 5 сарын 07-ны өдрийн хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.5-аар зааж өгсөн. Үндсэн 8 чиглэл бодлого, хөтөлбөрийг батлуулж явна. Үүнтэй холбоотой –

- Таван жилийн төлөвлөгөө гарна.
- Засгийн газрын дөрвөн жилийн мөрийн хөтөлбөр гарна.
- Жилийн төлөвлөгөө гараад явах ёстой.

Тэгэхээр Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.5 дээр байгаа үндсэн 8 чиглэлийн төсөл, хөтөлбөрүүдийг батлуулаагүй байж таван жилийн төлөвлөгөөгөө оруулж ирээд “хөгжлийн хөтөлбөр” гээд яриад байдаг. Энэ байдлыг зогсоомор байгаа юм.

Яг одоо хууль засаглах гээд байна уу, хүн засаглах гээд байна уу? Тэгээд дураараа орж ирж хуулиа өөрчилдөг. Одоо энэ төсөвтэй холбоотой асуудлууд ч гэсэн ил тод, нээлттэй явж байна шүү дээ.

Тэгээд л дураараа орж ирээд л төсвийн тусгай шаардлагуудтай холбоотой, төсөвтэй холбоотой Улсын Их Хурлын батлаад өгсөн төсвийн хүрээний мэдэгдлийг хүртэл дураараа өөрчилдөг, лобби хийдэг, гишүүдтэй нэг бүрчлэн ярьдаг, эрхэнд нь халддаг. Ийм байдлуудаа зогсоох хэрэгтэй шүү дээ.

Сүүлийн 10 жил Монгол Ардын намынхан дангаараа засаг барьж байхдаа засаг замбараагүй байсан байж болно. Одоо тийм биш шүү. Одоо энэ чинь 5 намын төлөөлөл ороод ирсэн. Ялангуяа Ардчилсан намынхан 42 гишүүн, 42 суудалтай энэ хуулийг хэрэгжүүлэхийн төлөө явна.

Тэгэхээр таван жилийн хөгжлийн хөтөлбөрөө үнэхээр батлуулах гээд явж байвал хуулийнхаа дагуу явах ёстой гэдгийг нэгд хэлье.

Хоёрт гэвэл “хөгжлийн хөтөлбөр биш, хөшөө зогссон хөтөлбөр болсон шүү” гэдгийг сануулсан.

Улсын Их Хурал 2020 онд “Алсын хараа-2050”-ийг баталсан. Үүнтэй холбоотой хавсралт дээр нь 73 шалгуур үзүүлэлттэй, ямар үзүүлэлтээр яаж индикатораар үнэлэх вэ. Тоон үзүүлэлттэй, хувиар заагаад өгсөн. Үүнийгээ ярихгүй. Сүүлийн таван жилийн хугацаанд юу хийсэн юм бэ? Бараг 120 орчим их наяд төгрөг төсвөөр дамжуулж хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдийг санхүүжүүлж хэрэгжүүлнэ гэсэн. Тэр ажил нь ямар үр дүнтэй байгаа юм.

Тэгээд тэр үр дүнгээ ярихгүй одоо өнөөдөр зүгээр сайхан ядуурлыг хоёр дахин багасгана, эдийн засгаа тэлнэ гээд яриад сууж байдаг. Тэгээд тэр шалгуур үзүүлэлт дээр бүр тодорхой. 2025 онд инфляцыг 7 хувь дээр барина гээд байлаа шүү дээ. Тэгэхэд өнөөдөр инфляц хэдэн хувьтай байгаа юм. 9 хувьтай. Бараг хоёр оронтой тоо руу орох гэж байгаа шүү дээ.

Тэгээд энэ гол гол асуудлуудаа ярихгүйгээр зүгээр нэг ийм урсгал маягаар сайхан өнгөрөөгөөд л, тэгээд энэ хөгжлийн таван жилийн хөтөлбөрийг батлуулна гэвэл жоохон эндүүрэл болох байх шүү гэдгийг бас хэлье.

Тэгээд мэдээж сайд нар нь 2026-2030 оны таван жилийн төлөвлөгөөгөө нэлээн бодож боловсруулсан гэж яриад байгаа. Ялангуяа Н.Учрал сайд түрүүн тоон үзүүлэлтүүдээр хэмжихэд бид боломжтой болгож байгаа гэж яриад байгаа. Яг үндсэндээ 2020 оны тогтоол дээр 73 индикатораар бүх үзүүлэлтүүдийг нь хэмжих тоон үзүүлэлттэйгээ байгаа юм билээ шүү.

Тэгээд тэрийгээ сайн харж нягтлаарай гэж хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Ч.Лодойсамбуу: Жадамбын Энхбаяр гишүүн алга байна. Гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3 дахь хэсэгт заасныг үндэслэн тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлаар санал хураалт явуулна.

Танхимд хуралдааны ирц бол 32 гишүүнээс 22 гишүүн ирсэн. 68.8 хувьтай байгаа. Санал хураалт явуулах бүрэн боломжтой байгаа. Танхимд байгаа гишүүд байхгүй байгаа гишүүдийг нэг удаа зарлаж дуудъя.

Жуковын Алдаржавхлан гишүүн орж ирж саналаа өгөөрэй.
Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн орж ирж саналаа өгөөрэй.
Отгоншарын Батнайрамдал гишүүн орж ирж саналаа өгөөрэй.
Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн орж ирж саналаа өгөөрэй.
Пүрэвийн Батчимэг гишүүн орж ирж саналаа өгөөрэй.

Жамбалын Ганбаатар гишүүн орж ирж саналаа өгөөрэй.
Пүрэвжавын Ганзориг гишүүн орж ирж саналаа өгөөрэй.
Батбаярын Жаргалан гишүүн орж ирж саналаа өгөөрэй.
Батжаргалын Заяабал гишүүн орж ирж саналаа өгөөрэй.
Мэндбаярын Мандхай гишүүн орж ирж саналаа өгөөрэй.
Бадрахын Найдалаа гишүүн орж ирж саналаа өгөөрэй.
Эрдэнэбилигийн Одбаяр гишүүн ирж саналаа өгөөрэй.
Бадамдоржийн Пунсалмаа гишүүн орж ирж саналаа өгөөрэй.
Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн орж ирж саналаа өгөөрэй.

Энэ санал хураалтын өмнө хоёрдугаар асуудлаа хэлэлцэж эхэлье.

Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх санал хураалтыг хоёрдугаар асуудлын санал хураалттай хамт явуулъя. Хэлэлцэх асуудал.

**Хоёр.Хууль, тогтоолын үүрэг, чиглэл болгосон
Улсын Их Хурлын шийдвэрийн
биелэлтийн тайлан**

Хоёр.Хууль тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудалд хамаарах Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтэд хийсэн дүн шинжилгээний тайланг Та бүхэнд тараасан байгаа.

Монгол Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Сангийн сайд Болдын Жавхлан Засгийн газрын мэдээллийг танилцуулна.

Сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын байнгын хорооны дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.9, 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалт болон Засгийн газартай Хяналтын тухай хуулийн 19.4-д заасныг үндэслэн Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журмын 3.7-д заасан аргачлалыг баримтлан Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шинжилгээний дүнг танилцуулж байна.

Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд Монгол Улсын 79 хуулийн 263, Улсын Их Хурлын 90 тогтоолын 491 заалт, Байнгын хорооны 69 тогтоолын 290 заалт, нийт 238 шийдвэрийн 1044 заалт бүртгэлтэй байна.

2025 оны эхний хагас жилийн байдлаар хууль, Улсын Их Хурлын болон Улсын Их Хурлын Байнгын хорооны шийдвэрийн хэрэгжилт дунджаар 46 хувь байна. Тухайлбал, Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний цахим санд бүртгэлтэй байгаа Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийг төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын харьяа агентлаг, аймаг, нийслэлийн төрийн захиргааны байгууллагаар авч үзэхэд 1044 заалтаас 40.6 хувь буюу 424 нь хэрэгжсэн, 47.7 хувь буюу 498 нь хэрэгжээгүй, 11.7 хувь буюу 122 заалт хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй гэж үнэлэгдсэн байна.

Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийг авч үзвэл:

Нэг.Хуулийн хэрэгжилт.

2025 оны эхний хагас жилийн байдлаар Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд 17 хуулийн 58 заалтыг төрийн захиргааны төв 16 байгууллага дунджаар 37.3 хувьтай хэрэгжүүлсэн байна. Үүнээс:

- 32.8 хувь буюу 19 заалт хэрэгжсэн,
- 55.2 хувь буюу 32 заалт хэрэгжээгүй,
- 12.1 хувь буюу 6 заалтыг хэрэгжүүлэх хугацаа болоогүй-

гэж тус тус дүгнэлээ.

Монгол Улсын 11 хуулийн 32 заалт хэрэгжээгүй бөгөөд уг заалтаар төрийн эрх барих байгууллага, албан тушаалтнаас захиргааны акт, хаяг батлан хэрэгжүүлэх эрх олгосон байна.

Хэрэгжээгүй 21 заалтаар журам 11, аргачлал 9, тавигдах шаардлага 2, төлөвлөгөө жагсаалт, стандарт тус бүр 1, нийт 25 захиргааны акт батлан хэрэгжүүлэхээр байна. Тухайлбал, Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 2022 оны шинэчилсэн найруулгын 7.2.11 дэх заалтаар баталгаажсан үйлдвэр, омгийн болон гойд ашиг шимт үржлийн мал, амьтны үнэлгээний журам, аргачлалыг санхүү, төсвийн болон хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран, мөн хуулийн 7.2.12 дахь заалтаар ашигт малтмалын болон газрын тосны орд, байгалийн хийн хөрөнгийн үнэлгээний журам, аргачлалыг уул уурхайн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 9.6.1 дэх хэсэгт хяналтын төхөөрөмж

суурилуулах, шаардлагатай тээврийн хэрэгслийн ангилал, төрөл, тээвэрлэлт, гүйцэтгэж байгаа тээврийн хэрэгсэлд суурилуулах, хяналтын төхөөрөмжид тавигдах шаардлага, хяналтын төхөөрөмжийг ашиглах үйлчилгээ хийх, үйл ажиллагааг хянах журмыг зам тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батлан хэрэгжүүлэхээр тус тус заасан байна.

Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт албан татвар ногдох авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийг бүртгэх бүртгэлээс хасах журмыг санхүү, төсвийн болон зам тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална гэсэн нь уг асуудлыг авто тээврийн тухай хуулийн 17¹.2-т заасан зарчмаар зохицуулна.

Ийнхүү тээврийн хэрэгслийн бүртгэж хөтлөх, шилжилт хөдөлгөөн, бүртгэлээс хасах журам батлах зохицуулалтыг дээрх хоёр хууль давхардуулан тогтоосныг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.7-д заасан бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх шаардлагад нийцүүлэх арга хэмжээ авах нь зүйтэй байна.

Мөн захиргааны акт батлуулах үе шатын ажил болох хэрэгцээ шаардлагыг урьдчилан судлах, төсөл боловсруулах, үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо хийх, холбогдох байгууллагуудаас санал авах, хэлэлцүүлэг хийх гэх мэт удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүй байгаатай холбоотой байна.

2.Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт.

Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хяналт, шинжилгээ, үнэлгээний цахим санд бүртгэгдсэн 28 тогтоолын 99 заалтын хэрэгжилт төрийн захиргааны төв байгууллагын 16 яамтад дунджаар 50 хувьтай байна. Үүнээс:

- 43.4 хувь буюу 43 заалт хэрэгжсэн,
- 43.4 хувь буюу 43 заалт хэрэгжээгүй,
- 13.1 хувь буюу 13 заалтын хэрэгжүүлэхжүүлэх хугацаа болоогүй –

гэж дүгнэсэн байна.

Улсын Их Хурлын тогтоолын тогтоолын хэрэгжээгүй 17 тогтоолын 43 заалтыг авч үзвэл Улсын Их Хурлын Тавнтолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2018 оны 73 дугаар зүйлийн 1.4 дэх заалтаар Эрчим хүчний яам, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд даалгасан Өмнөд бүсийн уул уурхайн төслүүдийн эрчим хүчний хэрэгцээг хангах цахилгаан станц болон нүүрс, химийн үйлдвэрийг Тавантолгойн ордыг

түшиглэн барих талаар шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүргийн хэрэгжилтийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд зураг төсөл, худалдан авалт, барилга угсралт, санхүүжилт багтаасан түлхүүр гардуулах EPC+F /Engineering–Procurement–Construction+Financing/ нөхцөлөөр худалдан авах ажиллагааг зохион байгуулах боломжгүй болсон тул зарим хуульд өөрчлөлт оруулах замаар төслүүдийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэн Эдийн засаг, хөгжлийн яамнаас хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, холбогдох яамдаас санал авч байгаа тухай тайлагнасан нь үр дүнгүй байна.

Мөн Улсын Их Хурлын Оюу Толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах 2019 оны 92 дугаар тогтоолын 1.7 дахь заалтаар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд даалгасан Оюу Толгой төслийн Монгол талын төлөөллийг хэрэгжүүлэгч байгууллагын санхүүгийн болон хүний нөөцийн чадавхыг олон улсын түвшинд хүргэж бэхжүүлэх заалтыг 2021 оны 103 дугаар тогтоолын 1 дэх заалтад 92 дугаар тогтоолын хэрэгжсэн гэж тайлагнасан хэдий ч дээрх заалттай холбоотой асуудлыг хөндөгдөөгүй тул уг заалтын хэрэгжилтийг хангаагүй бүрэн хэрэгжүүлсэн гэж үзэхээргүй байна.

Улсын Их Хурлын нүүрсний тээвэрлэлт, экспортын холбоотой асуудлаарх ерөнхий хяналтын сонсголын тайлантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2023 оны 8 дугаар тогтоолын 1.а заалтаар Зам, тээврийн яаманд даалгасан нүүрсний тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаанд гарсан зөрчлүүдэд дүн шинжилгээ хийн, шалтгаан нөхцөлийг тогтоож, түүнийг арилгах арга хэмжээ авах, хууль бус үйлдэл гарахаас урьдчилан сэргийлж, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх, холбогдох эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай хууль тогтоомжид өөрчлөлт оруулах төслөө Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

1.в дэх заалтаар Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Эдийн засаг, хөгжлийн яамдад даалгасан Байгалийн баялгийн үр өгөөжийг ард түмэнд тэгш, шударгаар хүртээх, баялгийн ашиглалт, хуваарилалтыг ил тод байдлыг хангах, олон нийтийн хяналтад оруулах, төсвийн сахилга бат хариуцлагыг сайжруулах хүрээнд Үндэсний баялгийн сангийн тухай Эрдэс баялгийн бүтээгдэхүүний ил тод байдлын тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд яаралтай горимоор өргөн мэдүүлэх, 1991 онд батлагдсан Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг хүчингүй болгох асуудлыг судлан үзэж, саналаа Улсын Их Хуралд танилцуулах зэрэг заалтуудыг холбогдох хуулийн төслийг боловсруулсан гэх тайлан ирүүлсэн ч Улсын Их Хуралд яаралтай горимоор өргөн мэдүүлээгүй.

Мөн 1991 онд батлагдсан Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газрын эрх олгох тухай хуулийг хүчингүй болгох асуудлыг судлан үзсэн талаар тодорхой тайлагнаагүй учраас хэрэгжүүлээгүй гэж үзэхээр байна.

Гурав.Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын хэрэгжилт.

Тайлан тооны эхний хагас жилийн байдлаар Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд гаргасан 22 тогтоолын 70 заалтын хэрэгжилт төрийн захиргааны төв 10 байгууллагад дунджаар 50 хувьтай байна. Үүнээс:

- 47.1 хувь буюу 33 заалт хэрэгжсэн,
- 47.1 хувь буюу 33 заалт хэрэгжээгүй,
- 5.7 хувь буюу 4 заалтыг хэрэгжүүлэх хугацаа болоогүй –

гэж тус тус дүгнэлээ.

Тус Байнгын хорооны-

- 2017 оны 2,
- 2018 оны 2,
- 2019 оны 1,
- 2020 оны 1,
- 2021 оны 4,
- 2022 оны 5,
- 2023 оны 3 тогтоолын

- нийт 18 тогтоолын 33 заалтын хэрэгжилт үр дүн гараагүй байна.

Тухайлбал, Улсын Их Хурлын Байнгын хорооны экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн газар Монголбанканд чиглэл өгөх тухай 2019 оны 4 дүгээр тогтоолын 1.3, Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд 2014 оны 8 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан төмөр замын дамжин өнгөрөх тээврийн хэлэлцээрийг соёрхон батлуулах ажлыг эрчимжүүлэх заалтыг Гадаад хэргийн яамнаас Боомтын менежментийн хамтын ажиллагааны комиссын 6 дугаар хуралдааныг 7 дугаар сарын 07-ноос 09-нд Улаанбаатар хотноо зохион байгуулах бөгөөд хуралдааны үеэр хэл хэлэлцээрийг Хятадын талд ойрын хугацаанд соёрхон батлахыг хүсэж, протоколд тусгахаар төлөвлөж байна гэж тайлагнасан нь тухайн ажлыг үр дүн гараагүй гэж үзэхээр байна.

Мөн Улсын Их Хурлын байнгын хорооны газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар 2021 оны 4 дүгээр сарын 5 дахь заалтаар “Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд даалгасан газрын тосны хайгуулын ажлыг эрчимжүүлэх замаар үйлдвэрийн түүхий эд, баталгаат нөөцийн хэмжээг нэмэгдүүлэх, үүнтэй холбогдон гарах хөрөнгө, санхүүгийн асуудлыг шийдвэрлэх заалтын хэрэгжилтийг урт хугацааны түвшинд хэрэгжих” гэсэн нь тус заалтыг хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээ аваагүй байна гэж үзэхээр байна.

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 18 дугаар тогтоолын 33 заалтын хэрэгжилтийг тухайн чиг үүргийг хүлээсэн байгууллагад тайлагнах хугацаанд хэрэгжүүлсэн ажил нь үнэлэгдэхгүйц ахиц гараагүй. Зарим тохиолдолд

тогтоолын нэг заалтаар өгсөн хэд хэдэн үүргийн зарим хэсгийг гүйцэтгээгүй, тухайн заалтын хэрэгжилтийг зарим байгууллага ирүүлээгүй байх тул хэрэгжээгүй гэж дүгнэлээ.

Харин Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Тур хорооны 2 тогтоол гарсан байна.

- ➔ Цахим бодлогын түр хороо “Чиглэл өгөх тухай” 2019 оны 5 дугаар тогтоолоор 2 үүрэг, чиглэл өгсөн бөгөөд нэг заалт бүрэн хэрэгжсэн, нэг заалт хэрэгжээгүй байна.
- ➔ Мөн Улсын Их Хурлын Байнгын хорооны “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2022 оны 3 дугаар тогтоолоор 14 үүрэг, чиглэл өгөгдсөн бөгөөд үүнээс 2 нь бүрэн хэрэгжсэн, 10 заалт хэрэгжээгүй, 2 заалт хугацаа болоогүй гэж гэж тус тус үнэлэгдсэн байна.

Дээрх хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолын 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний дүнгийн тайланг 2025 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр Засгийн газрын хуралдаанд танилцуулж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр Засгийн газрын гишүүд Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, Нийслэлийн Засаг дарга нарт үүрэг, чиглэл өгч биелэлтийг тооцон ажиллаж байна.

Дүгнэлт.

Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим хуудсанд бүртгэлтэй Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 67 шийдвэрийн 227 заалтын хэрэгжилт 45.8 хувь байна.

Тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Монгол Улсын 11 хуулийн 24 заалтаар төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтанд эрх олгосон захиргааны актыг батлах асуудлыг салбар бүрээр судлан үзэж, нэн яаралтай холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яамны эрх зүйн актын бүртгэлийн санд бүртгүүлж, хэрэгжилтийг ханган ажиллах нь зүйтэй байна.

Уншиж танилцуулж дууслаа.

Ч.Лодойсамбуу: Сангийн сайдад баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ням-Осорын Учрал, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Батаагийн Батцэцэг, тус газрын Үнэлгээ, мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Баатарчулууны Золбоо, тус газрын Үнэлгээ, мониторингийн хэлтсийн

даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Баатаржавын Баярсүх, тус газрын Үнэлгээ мониторингийн хэлтсийн референт Дүгэржавын Даваасамбуу.

Засгийн газрын мэдээлэлтэй холбогдуулаад асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье.

М.Мандхай гишүүнээр тасаллаа. Ирцийн дагуу Мэндбаярын Мандхай гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

М.Мандхай: Би хоёрхон л асуулт асууя гэж бодож байна.

Засгийн газрын хуулийн хэрэгжсэн хэсэг заалт дээр “аялал жуулчлалын тухай” гээд байгаа.

Энэ дээр 18.5 дээр хил орчмын нутаг дэвсгэрийн аялал жуулчлалын үйл ажиллагааг зохион байгуулах, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон журмыг Засгийн газар батална гээд 142 дугаар тогтоолоор баталсан юм байна.

Үүний хэр хэрэгжилт ер нь хэр явж байгаа вэ?

Гуравдагч орны жуулчид ер нь чөлөөтэй нэвтрэх, аялах боломж нээгдсэн үү? Өөрийнхөө унаагаар аялах нөхцөл бүрдсэн үү гэдэг асуултыг Ч.Ундрэм сайдаас асууя гэж бодож байна.

Дараагийнх нь, Хөдөлмөр эрхлэх сан гэж байгаа. Тийм ээ? Хөдөлмөр эрхлэх сан дээр жижиг, дунд үйлдвэрээс 416 аж ахуйн нэгж, байгууллага 59.3 тэрбум арилжааны банкаар олгохоор болсон. Үүний хэрэгжилт нь ямар түвшинд байгаа вэ? Нийт 130.7 тэрбум тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр хийсэн байна. Энэ ондоо амжихгүй гэсэн үг үү гэдэг асуултыг асууя.

Ч.Лодойсамбуу: Болсон уу?

М.Мандхай: Болсон.

Ч.Лодойсамбуу: Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

Б.Батцэцэг: М.Мандхай гишүүний асуултад хариулъя.

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар Б.Батцэцэг.

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар нь Засгийн газар дахь хяналтын тухай хуульд заасны дагуу хууль тогтоомжийг хагас жилээр хийсэн үнэлгээг оруулж ирэхдээ 2025 онд Засгийн газраас баталсан 43 дугаар тогтоол гээд өмнө нь үнэлж байсан 30-аас 70 хүртэлх хувийн үнэлгээнүүд бүгдээрээ “тэг” хувьтай буюу хэрэгжээгүй, үр дүн гараагүй гэсэн заалтаар орж ирж байгаа.

43 дугаар тогтоолын дагуу 85 хүртэлх хувийн хэрэгжилттэй бүх арга хэмжээнүүд хэрэгжээгүй, үр дүн гараагүй гэж үнэлэгдсэн учраас таны асуусан хоёр асуулттай холбоотойгоор яамдаас процессоо мэдэгдсэн тайлан манай дээр ирүүлсэн.

Тэгэхээр бид нарын үнэлсэн үнэлгээгээр 85 хүртэлх хувийн өөрчлөлт гараагүй учраас хэрэгжээгүй заалт гэж үнэлэгдсэн байгаа.

Тэгэхээр би яамд ямар процесстой явж байгаа гэдгийг нь яам төлөөлөх эрхгүй учраас бүрэн хариулт өгөхгүй байна.

Ч.Лодойсамбуу: Гишүүдийн асуултад гүйцэд хариулах ажлын хэсэгт нэрс нь орсон сайд орж ирж дэлгэрэнгүй хариулт өгмөөр байх юм.

М.Мандхай гишүүн тодруулах уу? М.Мандхай гишүүн тодруулъя.

М.Мандхай: Би дахиад. Жишээлбэл, 4 дээр Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт дээр ажлын байрыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хоршоонд олгох санхүүжилтийн жил бүрийн улсын төсөвт тусгуулна гэсэн.

Тус хөтөлбөрөөр жишээлбэл санхүүжих дүн нь 130.7 тэрбум төгрөгийг 2025 оны төсвийн тухай хуульд тусгуулаад нийтдээ тайлант хугацаанд 59.3 тэрбум төгрөгийн санхүүжилт бүхий 416 аж ахуйн нэгж хүсэлтээ баталгаажуулж ирүүлснийг ажлын хэсэг шалгаж эхэлсэн гэсэн байгаа.

Тэгэхээр үүний хэрэгжилт нь ямар түвшинд байгаа юм бэ? Үр дүн гарсан юм уу? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, 57 дугаар тогтоолоор бас нэг ийм юу байсан. 57 биш ээ. “Хүнсний хувьсгал”, “Цагаан алт”, “Атрын-IV” аян гээд хөдөө аж ахуйтай холбоотой хөтөлбөрүүд байгаа шүү дээ. Тийм ээ.

Ч.Лодойсамбуу: Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

Б.Батцэцэг: Гишүүний тодруулгад нэмэлт хариулъя.

Та сая яамдаас ирүүлсэн тайлангуудыг уншлаа. Энэ бол 6 сарын 31-ний өдрийн байдлаар тасалж ирүүлсэн мэдээлэл.

Бидний хувьд яг яамдын хийж байгаа үйл ажиллагаа мөн л адилхан 6 сарын 31-ний өдөр тасалсан мэдээллээрээ байгаа. Яамд өөрсдөө үүнээс хойших ажлынхаа үр дүнг илүү тодорхой хариулах байсан болов уу гэж бодож байна.

Бид яамдын ирүүлсэн тайлан дээр 43 дугаар тогтоолоор заасан аргачлалын дагуу үнэлгээг хийж оруулж ирсэн. Тэр үнэлгээний дагуу энэ ажиллагаа үр дүнгүй гэж үнэлэгдсэн.

Ч.Лодойсамбуу: Дахиад тодруулах юм уу? Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн асуултаа асууя.

Д.Үүрийнтуяа: Санал тусдаа билүү? Цуг ярина. Тийм ээ.

Хоёр, гурван асуулт байна. Гүйцэтгэл хуулийнх 30 гаруй хувьтай. Улсын Их Хурлын тогтоолын төсөл 40 хэдэн хувьтай гээд. Гүйцэтгэл нэлээн хангалтгүй сонсогдож байна.

Хэрэгжихгүй байгаа шалтгаан нь хэрэгжих боломжгүй хууль тогтоомжийн зүйл, заалт байгаад хэрэгжих боломжгүй хууль тогтоомжийг Улсын Их Хурлаас гаргаж өгөөд байна уу, аль эсвэл хэрэгжүүлэх шатад хариуцлага хүлээсэн албан тушаалтнууд хийх ёстой ажлаа хийхгүй байна уу? Үүнийг тодорхой болгож өгөөч.

Одоогоор Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо. Нийгмийн бодлогын байнгын хороогоор мөн ялгаагүй хууль тогтоомжийн хэрэгжилтийг орж байхад би Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх байгууллагаас тухайн үед Э.Одбаяр сайд байсан. Мөн л энэ асуултыг асууж байсан. Хэрэгжүүлэхгүй байгаа хүмүүстээ ямар хариуцлага тооцдог юм? Хэрэгжилтийг дагуулж арга хэмжээ тооцсон, санал боловсруулсан зүйл байна уу?

Бидэнд тараасан материал мөн л ялгаагүй. Хаврын чуулган дээр Улсын Их Хурлын 52, 54 дүгээр тогтоолууд Байнгын хороодоор орж байх үед би бас л хэлж байсан. Энэ нэг тайлан гаргаж байгаа юм шиг ямар ч гар хөлийн үсэггүй нэг ийм хүснэгт ирдэг юм. Хэн хийсэн нь бүү мэд. Араас нь дүгнэлт гээд нэг юм ирдэг юм.

Хуулийн нэртэй хэсэг заалттай. Заалтын агуулгатай. Хэрэгжилт гээд хэдэн өгүүлбэртэй. Заалт болгоноороо тэр чинь хувь тавьдаггүй юм уу? Сайд нэг тоо хэлээд байгаа юм. Тэр нь хаанаас гарч ирээд байдаг юм. Үүнийг чинь яаж тооцдог юм. Тэгээд яг хаврын чуулганаар ярьж байсан бахь байдгаараа.

Төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт, төлөвлөлт гэдэг эргэх холбоо циклээр ажил чинь явдаггүй юм уу? Бид ерөөсөө төлөвлөгөө, төсөв ярихаараа л ёстой хамаг ухаан санаа, оюун бодол, бүх юмаа тэн дээр хаяж байгаад л араас нь гүйдэг. Гүйцэтгэлээ ерөөсөө тоодоггүй. Гүйцэтгэлээ тоохгүйгээр ер нь яаж төлөвлөх юм бэ?

Гүйцэтгэлд суурилсан, түүндээ үнэлэлт дүгнэлт өгсөн, дараа дараагийнхаа анхаарах ёстой асуудлуудаа гаргаж ирсэн төлөвлөлт чинь дараагийнхаа ажлууд дээр үр дүн өгдөггүй юм уу? Мөнгө юу зарж байгаадаа анхаардаггүй юм уу? Энэ дээр тодорхой хариулт өгөөч ээ.

Эдийн засаг, хөгжлийн яам руу бас хяналтын чиг үүрэг очоод ер нь ямар өөрчлөлт гарав? Юу өөрчлөгдсөн юм? Тараасан материал дотроос би ямар нэг өөрчлөлт олж харахгүй байна. Эсвэл бодлогын шинжтэй ажлууд үргэлжлээд явж байна уу? Тодорхой хариулт авъя.

Ч.Лодойсамбуу: Б.Батцэцэг дарга хариулъя. 3 дугаар микрофон.

Б.Батцэцэг: Д.Үүрийнтуяа гишүүний гурван асуулт байна.

Нэгдүгээр асуулт. Хэрэгжих боломжгүй хууль тогтоомж гараад байна уу, яагаад хэрэгжилт бага хувьтай байгаа юм бэ гээд.

Сүүлийн хоёр жил үнэлсэн үнэлгээнүүдийг харахаар харьцангуй гишүүдийн хэлээд байгаачлан үнэлгээ их доор байгаа. Энэ удаагийн үнэл тэгээд бүр доошоо болж орж ирсэн.

Эхнийх нь миний ярьсан 85 хүртэлх хувийг үр дүнгүй гэж үнэлдэг. Үр дүнд суурилсан үнэлгээг хийх гэж оролдож байгаатай холбоотойгоор буурч орж ирж байгаа.

Мэдээж яагаад хэрэгжихгүй байгаа юм бэ гэдэг шалтгааныг зүгээр тайлагналтаас нь бид аваад үзэхээр хэд хэдэн шалтгаан байна.

- ▷ **Нэгдүгээрт**, механик талаас нь аваад үзвэл буцаад Засгийн газар доторх байгууллагууд тайлангаа ирүүлэхдээ өмнөх тайлангаа сору-paste хийж, эсвэл тайлангаа бүр ирүүлдэггүй байгууллагууд байгаад байна. Энэ бол хуулийн хугацаатай.
- ▷ **Хоёрдугаарт**, журам батална гээд баталдаггүй. Ялангуяа хяналтад байгаа хуулиуд, журам батлах заалтуудыг хяналтад авсан. Тэр нь батлагдахгүй яваад байгаа зохицуулалтууд байна.

Тайлагнахдаа зөвхөн төсөл боловсруулсан, төсөлд тусгасан гэдэг байдлаар тайлагнасан асуудлууд нь бүгд “тэг” хувьтай байгаа.

Тайлагналт дээр дараагийн нэг асуудал нь хууль тогтоомж дээр юу гарч ирдэг вэ гэхээр бид Хяналт хэрэгжүүлэх тухай хуулийн дагуу 7 сард Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт орохоос өмнө хяналтын газар хууль тогтоомжийн хэрэгжилтийг тайлагнаж явж байсан.

2025 оны жилийн эцсийг Хэрэг эрхлэх газраас тайлагнана. Тайлагнаад явж байх хооронд асуудал нь юундаа гардаг вэ гэхээр Их Хурлаас удирдлага нь томилогддог байгууллагууд тайлангаа өгдөггүй асуудал бас байна. Засгийн газрын үнэлгээнд бид нарын ажил үнэлэгддэггүй гэдэг. Энэ нь байгууллагуудын удирдлагуудын хоорондын ойлголцлын асуудал байна.

Бас нөгөөтээгүүр байгууллагуудын зохион байгуулалт, уялдаа холбооны асуудлууд байсаар байгаа. Үүнийг Засгийн газар дотроо хүлээн зөвшөөрч байгаа.

Бидний хувьд хууль тогтоомжийг таван жилийн үндсэн чиглэлийг, Монгол Улсыг хөгжүүлэх жилийн төлөвлөгөөний тайлан бүгдийг нь оруулаад базаад яасан гэхээр төсвийн ерөнхийлөн захирагч нарт чиглэл хүргүүлсэн байгаа. 11 сарын 15-ны өдрөөр тасалбар болгоод хийсэн ажлынхаа үр дүнг Хэрэг эрхлэх газар дээр тайлагнана.

43 дугаар тогтоолоор бас нэг гарсан томоохон өөрчлөлт нь юу вэ гэхээр бид хэрэгжихгүй үр дүнгүй үнэлэгдсэн заалтууд дээр бодит үр дүнгийн үнэлгээг хийх боломж энэ тогтоолоор бүрдсэн.

Тэгэхээр манай байгууллага дээр хоёр удирдамжтай 30 гаруй хүний ажлын хэсэг гараад бид төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламжийн төсөл, хөтөлбөрүүдийн үр дүнгүй гэж хэрэгжсэн заалтуудыг газар дээр нь очиж үнэлэх ажлыг хийгээд явж байгаа.

Нөгөө талаар тогтолцооны хувьд бас асуудал байгаа. Түрүүн сайдын илтгэлд дурдсан. Заримдаа давхардсан шинжтэй тайлагналт нь ижил яваад байгаа хуулийн заалтууд байна.

Тэгэхээр бид кодификац хийх зайлшгүй шаардлагатай. Нөгөөтээгүүр Их Хурал, Засгийн газар талаасаа аваад үзэх юм бол бид нарт хяналтад авсан заалтууд зөрүүтэй байгаа. Үүнийг бид систем холболтоор цахимжилтын боломжоор шийдвэрлэх боломж байгаа.

Дараагийн асуудал нь яах аргагүй төсөв мөнгө дээр очиж тулдаг асуудлууд байна. Бид үүнийг засах гээд ажлын хэсэг гаргаад ажиллаж байгаа юмнууд байгаа.

Хариуцлага тооцсон уу гэхээр яах вэ энэ удаагийнхаар биш, гэхдээ өмнө нь 3 аймгийн Засаг дарга, 3 Төрийн нарийн бичгийн дарга нарт хууль тогтоомжийн хэрэгжилтийн хүрээнд Хэрэг эрхлэх газраас хариуцлага тооцсон тохиолдол байдаг юм билээ. Энэ удаагийн 2025 оны хагас жилийн тайлан дээр чиглэл өгсөн албан бичиг хүргүүлсэн байгаа. Хагас жилийнх учраас. Энэ явцыг үнэлж байгаа учраас.

2025 оны жилийн эцсийн тайлангаар магадгүй хариуцлага тооцсон асуудлыг хэрэг эрхлэхээс илүү тодорхой мэдээлэх болов уу гэж бодож байна.

Ч.Лодойсамбуу: Д.Үүрийнтуяа гишүүн тодруулъя.

Д.Үүрийнтуяа: Гүйцээгээд хариулах юм уу?

Н.Учрал: Гүйцээгээд хариулъя. Б.Батцэцэг дарга.

Б.Батцэцэг: Эдийн засгийн яаман дээр хяналтын чиг үүрэг шилжиж ирэхдээ зөвхөн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн үнэлгээ хяналт шинжилгээний ажил шилжиж ирсэн байгаа.

Тэгэхээр үүний үр дүн саяын Байнгын хорооны хэлэлцэх асуудлын нэг дээр байсан таван жилийн үндсэн чиглэлийг бид илүү үр дүнд суурилсан, илүү хэмжиж болохуйц төлөвлөлтөд нь дөхөм болсон юм болов уу гэж харж байгаа. Таван жилийн үндсэн чиглэлийн тайланг бид бас таван жилээр нь үнэлсэн байгаа. Үнэлгээ харьцангуй муу гарсан. Шалгуур үзүүлэлтүүд байхгүй байсан. Шалгуур үзүүлэлтүүдийг илүү нарийвчлах дээр хяналт хэрэгжүүлэх газар орж ажилласан.

Ч.Лодойсамбуу: Д.Үүрийнтуяа гишүүн тодруулъя.

Д.Үүрийнтуяа: Та яриад байна л даа. Одоо тэгээд тайлангаа Засгийн газрын агентлагууд сору-paste хийдэг. Өмнөх тайлангаа ирүүлдэггүй гээд. Журам батална гээд баталдаггүй гээд.

Энэ дээр яагаад танайх хяналт хэрэгжүүлэх газар хяналт хийчхээд, болохгүй байна гэххээд санал оруулахгүй байгаа юм.

Өмнө нь тийм түүх хоёр гурван удаагийнх байдаг юм байна гэж яриад байгаа юм. Би үүнийг л харин ойлгохгүй байна л даа. Ер нь тэгээд нэг ийм тайлан гаргаад л, хувь ч байхгүй хэдэн хүснэгтээр баахан цаас бэлдээд л, Байнгын хороон дээр орж ирээд л сонссон болоод л гарах юм бол үүнийг ер нь хийх хэрэг юу байгаа юм. Ямар үр дүнтэй юм. Хайран цагийн гарз биз дээ.

Тэгээд хяналтад авсан заалт зөрүүтэй гээд. Би 1 минутаа нэмээд авч болох уу? Хяналтад авсан заалт зөрүүтэй гээд байгаа юм. Энэ нэг программ байгаад байх шиг байгаа юм.

Тэгээд яг өнгөрсөн жил Э.Одбаяр сайд яг үүнийг яриад л сууж байсан. Бүтэн жил боллоо шүү дээ. Тэгээд яагаад зөрүүгээ арилгахгүй байгаа юм. Яг л үүнийг яриад л сууж байсан шүү дээ.

Тэгээд дараа жил яах юм. Дахиад хэдэн тайлан гаргахаар дахиад л нөгөө хяналтад авсан заалтууд нь зөрүүтэй. Нэгтгэж чадахгүй. Программ дээрээ нэгтгэж чадахгүй байгаа гээд л дахиад л ингээд сууж байх юм уу? Тэгээд л хүснэгт нь яг энэ хэвээрээ, гүйцэтгэл, хувиа ч тавьдаггүй энэ хэвээрээ л орж ирсээр л байх уу?

Эдийн засаг, хөгжлийн яам руу энэ хяналтын чиг үүрэг нь шилжсэн гэж ойлгосон. Зөвхөн хөгжлийн төлөвлөлт, бодлого нь бодлоготой холбоотой асуудал нь шилжсэн юм бол тэгээд танай байгууллага чинь ер нь хэд хуваагдаад байна аа? Хэдэн даргатай байгаад байна аа? Тэгээд энэ үр дүнд суурилсан төлөвлөлт гэдэг зүйл дээр хариулт өгөхгүй юм уу? Яаж ажиллах ёстой юм бэ?

Н.Учрал: Хариулъя. 3 номерын микрофон.

Б.Батцэцэг: Засгийн газар дахь хяналтын тухай хуулиар –

- хяналт хэрэгжүүлэх газар, байгууллага, албан тушаалтан дээр арга хэмжээ авах эрх мэдэл байхгүй.
- ➔ Бид хяналт, шинжилгээ, үнэлгээ хийдэг.
- ➔ Ажил сайжруулах саналаа Засгийн газрын хуралдаанд танилцуулдаг.
- ➔ Засгийн газрын хуралдаанаас тогтоол, эсхүл тэмдэглэлээр үүрэг чиглэл болгож холбогдох байгууллагуудад үүрэг чиглэл явдаг.

Бидний хувьд томилох эрх бүхий албан тушаалтанд нь хариуцлага тооцуулахаар 5 яаманд хандсан албан бичиг байгаа. Тайлан мэдээ нь ирэхээр би танд илүү дэлгэрэнгүй танилцуулах боломжтой.

Яагаад тоогоор илэрхийлэгдсэн юм байхгүй байна вэ гэхээр өмнө нь 30-аас 70, 70-аас 100 гэж үнэлдэг байсан юм билээ. Тэнд тоон илэрхийлэл орж ирдэг байсан. Хяналт шинжилгээ, үнэлгээний хувьд үр дүнд суурилсан хяналт шинжилгээ... /минут дуусав/

Н.Учрал: Гүйцээгээд хариулъя.

Б.Батцэцэг: ... хийнэ гэдгээр Засгийн газар 2025 оны 43 дугаар тогтоол гээд. Энэ Э.Одбаяр сайдын үед батлагдсан тогтоол. Байгууллага, албан тушаалтан хууль тогтоомжийн үнэлгээнд шинэ түвшинд гаргаж ирсэн тогтоол батлагдсан байгаа. Энэ дагуу би түрүүн хэлсэн. Томьёонд оруулж бодоод 85 хүртэлх нь ерөөсөө үр дүн гараагүй л гэж үнэлэгдээд байгаа.

Тэгэхээр 85-аас дооших нь хэдэн хувь ч байсан үр дүн гараагүй гэдэг нь Та бүхэнд тараагдсан материал дээр байж байгаа болов уу.

Ч.Лодойсамбуу: Ганбатын Очирбат гишүүн асуултаа асууя.

Г.Очирбат: Юуны түрүүнд хяналт шинжилгээний үндэсний мэргэжилтэн албан хаагч нарт баярлалаа гэж хэлэх гэсэн юм. Яагаад гэхээр энэ тоонуудыг сонсож байна гэдэг чинь болж байгаа юм л даа.

Тэгээд үүнийгээ шударгаар гаргаж ирээд –

- Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлт 48 хувьтай,
- Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжээгүй заалт 54 хувьтай,
- Байнгын хорооных 45 хувьтай байна гэж байгаа юм.

Тэгэхээр ер нь Засгийн газар ажлаа хийхгүй байна гэсэн үг шүү дээ.

➤ Монгол Улс парламентын засаглалтай.

➤ Байнгын хороод ажилладаг.

➤ Үүрэг чиглэл өгдөг.

➤ Өгч байгаа даалгавар, үүрэг чиглэл чинь 47 хувьтай байна л гэж бодох хэрэгтэй.

Тэгээд үнэнээ хэлж байна шүү дээ. Яамд тайлангаа өгөхгүй байна. Түрүү жилийнхээ тайланг copy-paste хийгээд явуулж байна. Хуулийн дагуу шаардлага тавихаар биелүүлэхгүй байна. Материалаа өгөөд ажлаа дүгнүүлээдхээч ээ гэхээр дүгнүүлэхгүй байна. Халгаж зугтаагаад байна гээд хэлж байна шүү дээ. Үнэнээ хэлж байна шүү дээ. Сайн байна. Улам сайн ажиллах хэрэгтэй.

Парламентын засаглал яах ёстой юм. Бид гүйцэтгэх засаглалаа хянах ёстой. Гүйцэтгэх засаглалын нөхөд чинь ажлаа хийж чадахгүй байна гэдгийг энэ мэргэжилтэн, мэргэжлийн байгууллагууд нь гаргаж ирээд хэлээд байна шүү дээ.

Тэгэхгүй тэгээд энд 4 залуугаас юу асуух юм. Бид. Тоогоо тайлантай, бодитой факттай бид нарт тайлбарлаад хэлээд асуудал ийм байна шүү гээд оруулж ирж байна шүү дээ.

Тэгээд одоо бид парламент, Их Хурлын гишүүд юм бол, парламентын засаглалтай юм бол энэ засаг барьж байгаа нөхөдтэй хэзээ яаж хариуцлага тооцох юм бэ? Ядаж салбар салбараар нь барьж аваад тэр салбарын яамд дээр нь хариуцлага тооцъё л доо.

Энэ дээрээ бид ажлаа илүү нягтаршуулж явуулах хэрэгтэй байна. Тэгэхгүй улс төржүүлэлтээс болоод энэ улс эх орны ажил явдаггүй. Энэ ажилтан, албан хаагч нарын дүгнэлтээ гаргаад ирэхээр өөрсдөөс нь буцаагаад асуулт асуудаг. Буцаад хариулт авах гээд байдаг. Энэ байдлаа таслан зогсоогоод парламентын засаглалтай юм бол Их Хурлын гишүүд Их Хурлын гишүүн шиг байгаад, гүйцэтгэх засаглал гэж байгаа юм бол гүйцэтгэх засаглалаа гүйцэтгэх засаг шиг нь ажиллуулах хэрэгтэй байна. Чадахгүй бол үүнийг болиулах хэрэгтэй.

Тийм байна. Та хэд ажлаа илүү сайн нягтаршуулж хийгээрэй. Энэ тоонуудаа илүү үр дүнтэй болгоорой. Үнэнийг нь ил хэлээрэй. Айж агшиж, янз бүрийн сайд, дарга нар, албан тушаалтнууд дарамтлах юм бол үүнээс айж тоон мэдээллүүдийг нууж болохгүй шүү гэж хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Н.Учрал: Г.Очирбат гишүүн, Д.Үүрийнтуяа гишүүн нартай санал нэг байна.

➤ **Нэгдүгээрт,** Б.Батцэцэг дарга хэн нь тайлангаа copy-paste хийснийг нэрлэе.

➤ **Хоёрдугаарт,** хэн нь ирүүлэхгүй байгааг бас нэрлэе.

Энэ бол Их Хурал шийдвэр гаргачхаад тэр шийдвэрийнхээ биелэлтийг хянадаг газар бас байгуулчхаад тэгээд түүнийхээ тайлан мэдээллийг хэдүүлээ сонсохдоо ингээд байна гээд нэр хаяггүй гомдлоо суугаад бас өнгөрмөөргүй байгаа. Энэ цаг хугацааг бас үр бүтээлтэй болгохын тулд ямар байгууллага, ямар газар copy-paste хийсэн, ямар газар нь ирүүлэхгүй байгаа вэ? Хэлье. 3 номер.

Б.Батцэцэг: Бид тайлан ирүүлээгүй асуудлаар Засаг дээр танилцуулга хийсэн. Нээлттэй бүгдэд нь мэдээлэл өгсөн.

- ▶ Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам,
- ▶ Зам, тээврийн яам,
- ▶ Эрүүл мэндийн яаман дээр асуудал байсан.
- ▶ Хүнс, хөдөө аж ахуйн яаман дээр бас тайлагналт дутуу юмнууд байсан.

Н.Учрал: Дутуу ирүүлсэн нь энэ хэд юм байна. Тийм үү?

Б.Батцэцэг: Тийм.

Н.Учрал: Copy-paste.

Б.Батцэцэг: Энэ хэдэн яаман дээр нийтлэг. Зарим нь copy-paste хийсэн. Зарим нь дутуу ирүүлсэн юмнууд байсан.

Н.Учрал: Аль нь copy-paste хийгээд, аль нь дутуу ирүүлсэн юм?

Б.Батцэцэг: Би танд excel-ийн file хараадахъя.

Хамааралгүй асуудлаар тайлагнасан юмнууд байгаа. Бас арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан эсэх нь тодорхойгүй, ерөнхий хяналтын сонсголын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах.

Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн “Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хөрөнгийн үнэлгээний үндэсний стандартыг үнэлгээний олон улсын стандартын зарчим болон энэ хуульд нийцүүлэн батална” гээд. Өмнөх тайланг давтан тайлагнасан. Тайлант онд зохион байгуулалтын арга хэмжээ авч гүйцэтгээгүй гээд.

Их Хурал, бүх Байнгын хороодоор задалсан excel file бид нарт байгаа байхгүй юу. Шаардлагатай бол авч үзэж болно.

Н.Учрал: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

Хууль тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлттэй танилцаж дууслаа. /алх цохив/

Одоо Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэхийг санал хурааж шийднэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3 дахь хэсэгт заасныг үндэслэн тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдье.

Санал хураалтыг нэг удаа явуулна. Төхөөрөмжөөр гацлаа гэдэг горимын санал гаргах дэгийн зохицуулалт байхгүй учраас анхааралтай байж саналаа өгөхийг хүсье. Санал хураалтыг явуулъя.

Нэг. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалт 24 гишүүнээс 12 гишүүн зөвшөөрснөөр. Одоо энэ 50.0 хувьтай уначхаж байгаа. Тийм ээ. Санал хураалт дууссан.

Санал хураалт явуулж дууслаа. /алх цохив/

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаар. Одоо энэ чинь чуулганаар орохгүй болчхож байгаа. Тийм ээ. Энэ нь орох уу? Тийм ээ.

Явуулсан талаар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ? М.Энхцэцэг гишүүн танилцуулна.

Тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдөр хэлэлцэх асуудал дуусаж хуралдаан үүгээр өндөрлөж байна.

Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

Хуралдаан 3 цаг 26 минут үргэлжилж, 15 цаг 56 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД